



ХӨДӨЛМӨР,
НИЙГЭМ ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ-ГАРААНЫ БИЗНЕС ГАРЫН АВЛАГА

Хөдөлмөр эрхлэлт, залуучуудын салбарын ажилтнууд,
гарааны биенес эрхлэхийг хүсэгч залуучууд,
ажил олгогчид, сонирхогч талуудад
зориулан Хөдөлмөр эрхлэлтийн
үндэсний зөвлөлөөс хэвлүүлэв.

Тараа сайн бол бариа сайн
Startup-Цахиур хагалах бизнес

Улаанбаатар хот
2017 он

ЗАЛУУЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ-ГАРААНЫ БИЗНЕС ГАРЫН АВЛАГА

Хэвлэлд бэлтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Д.Хадхүү

Хянан тохиолдуулсан: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Амартөгс

Цаасны хэмжээ	В5
Хэвлэлийн хуудас	5
Хэвлэсэн газар	Эдмаркет ХХК
Огноо	2017.10.20

ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ-ГАРААНЫ БИЗНЕС ГАРЫН АВЛАГЫН АГУУЛГА

№	Гарчиг	Товъёог
1	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт-гарааны бизнесийн талаарх танилцуулга мэдээлэл	1-6
2	“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт бизнесийг дэмжих хөтөлбөр” ХЭҮЗ-ийн 1 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт	7-12
3	“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын удирдамж, зөвлөмж батлах тухай” ХХҮЕГ-ын даргын А/106 тоот тушаал	13-16
4	“Гарааны бизнесийг дэмжих загварыг туршилтаар хэрэгжүүлэх удирдамж батлах тухай” ХХҮЕГ-ын даргын А/242 тоот тушаал	17-24
5	“Залуучуудын гарааны бизнесийг дэмжих загвар схем” ШХА-ийн Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн загвар схем	25-36
6	“МСҮТ-ийн төгсөгч, суралцагчдын гарааны бизнесийг дэмжих сургалтын хөтөлбөр” Гарааны бизнесийн зөвлөхүүдийн загвар	37-39
7	“Сумын залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр” Гарааны бизнесийн зөвлөхүүдийн загвар	40-42
8	“Гарааны бизнес, энтрепренёршип/бизнес эрхлэлтийн нэр томъёоны тайлбар толь”	43-62
9	“Залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдаж эхний байруудад шалгарсан төслүүдийн мэдээлэл	63-65
10	START UP-ын үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, мэргэжлийн боловсролын салбарын байгууллагын танилцуулгаас	66-70

ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ-ГАРААНЫ БИЗНЕСИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ

Гарааны бизнес, энтрепренершипийн хөгжлийн олон улсын туршлага, Монгол улсад энэ чиглэлээр явуулж буй үйл ажиллагаанд судалгаа явуулсны үндсэн дээр хот болон аймаг орон нутагт хөтөлбөр төслийн хүрээнд залуучуудын гарааны бизнесийг дэмжиж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Хөтөлбөрийн танилцуулга:

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ хэлбэр болсон гарааны бизнесийг хөгжүүлэхэд энтрепренершип¹-ийн өнөөгийн байдлын судалгаа, олон улсын гарааны бизнесийг дэмжих загвар, туршлага, манай улсад үйл ажиллагаа явуулж буй гарааны бизнесийг дэмждэг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын хэрэгжүүлдэг хөтөлбөр, үйл ажиллагаанууд дээр дүгнэлт хийсэн болно.

Түүнчлэн аймаг орон нутагт гарааны бизнесийг хөгжүүлэх, тухайн аймгийн гарааны бизнесийн экосистемийг төлөвшүүлэх, залуучуудаар удирдуулсан гарааны бизнесүүдийг төрүүлэн гаргаж, дэмжих, орон нутгийн залуучуудыг сургаж, гарааны бизнес эрхлэх мэдлэг чадвартай, сэтгэхүйтэй болгох зорилгоор гарааны бизнесийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна.

Хөтөлбөрийн сургалт арга хэмжээний зорилго:

Аймаг нийслэлд энтрепренершипийг хөгжүүлэх, гарааны бизнест залуучуудын оролцоог нэмэгдүүлэх зорилготой мэдлэг, мэдээлэл өгөх;

Залууст гарааны бизнесээ эхлүүлэх, өргөжүүлэх сэдэл, урам зориг өгөх, гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ өргөжүүлэх мэдлэг, мэдээлэл өгөх, оролцоог нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах;

Шилдэг бизнес санаануудыг шалгаруулж гарааны бизнесийг дэмжих 3 өдрийн арга хэмжээнд хамруулсаны дараа зохих бизнес санааг шалгаруулна;

Төслийн хүрээнд санхүүгийн дэмжлэг авах гарааны бизнес эрхлэгч шилдэг залуучуудыг шалгаруулах;

Залуучуудаар удирдуулсан шинэлэг гарааны бизнесийг дэмжих, гарааны бизнесээ хөгжүүлэх хурдасгуур хөтөлбөрт хамрагдах багийг шалгаруулах.

Сургалт, арга хэмжээ: 3 өдөр үргэлжлэх бөгөөд амралтын өдрүүдэд илүү тохиромжтой байна. Сургалт арга хэмжээний өмнө нийтэд зарлан мэдээлж бүртгэл хийнэ.

Оролцогчид: Нийт 50 хүн (Гарааны бизнес эрхлэх сонирхолтой бүртгүүлсэн залуучуудаас бизнес санаа нь шалгарсан хөтөлбөрт хамрагдах 50 залуу)

¹ Маш гайхалтай санааг аваад амжилттай ажил хэрэг болгох хүртэлх бүхий л саад бэрхшээлийг даван туулж, хөдөлмөрлөж амжилтад хүртэл удирдан явах үйл явцыг хэлнэ.

Сургалтын агуулга:

Залуучуудын гарааны бизнесийг дэмжих туршилтын хөтөлбөрийн танилцуулга
“Гарааны бизнес, энтрепренершипийн үндсэн ойлголт” сургалт, лекц
Загварчлах сэтгэлгээний сургалт
“Бизнес Моделийн Хавтгай” ашиглах сургалт
Гоогл апп-ийн хэрэглээний сургалт

Сургалтуудын ерөнхий танилцуулга:

Тус сургалтууд нь энтрепренершип, гарааны бизнесийн суурь мэдлэгүүдийг залуучуудад хүргэх зорилготой.

1. Design Thinking / Загварчлах сэтгэлгээ

Сургалт нь Стайнфордын их сургуулийн үндсэн хэлбэрээр явагдах бөгөөд сургагч багш чиглүүлэгч нь хамгийн түрүүнд танилцуулга хийсний дараа залуучууд хамтрагчаа олж 2 цагийн турш өөрсдийн биеээр хийх юм. Сургагч багш болон Чиглүүлэгч нар нь сургалтын турш хамт чиглүүлж ажилуулах болно.

2. “Бизнес модель хавтан” ашиглах сургалт

Гарааны бизнес, төсөл, санааг хамгийн хялбар, үр дүнтэй аргаар боловсруулах буюу тухайн бизнес хэрхэн явагдахыг тодорхойлдог Бизнес Модель Канвасыг хэрхэн амжилттай ашиглах талаар сургалт орох болно. Оролцогч хүмүүс баг болон хуваагдаж нэг баг нэг канвас дээр сургагч багшийн хамт ажиллах болно.

3. Бизнесээ хэрхэн зөв, амжилттай эхлүүлэх вэ ? Лекц

Лекц хэлбэрийн сургалт буюу амжилттай явж буй гарааны бизнесээ эхлүүлсэн илтгэгч өөрийн туршлага мэдлэгээ оролцогч залууст хуваалцаж яриа хийх болно. Асуулт хариулт нээлттэй явагдана.

4. “Google Apps” хэрэглээний сургалт

Google-н хэрэглээний аппуудын ажил, төсөл, багаараа хэрхэн ашиглах талаар суралцах бөгөөд уг сургалтаар хүн бүр бизнестээ хэрэглээний аппуудыг ашиглаж сурна.

Питч (pitch) арга хэмжээний хөтөлбөр

Сургалт дууссаны үргэлжлэн эхлэх бөгөөд дараах хөтөлбөрийн дагуу явагдана. (Бизнес санаануудын танилцуулга, шалгаруулах, бизнес модел боловсруулах, мэнторинг, зөвлөх, шилдэг гарааны бизнесийг шалгаруулах арга хэмжээ)

Уг хөтөлбөр нь эхний өдөр санал хураасны дараа чадварлаг багуудад хуваагдаж, шилдэг санаануудыг гаргаж, бизнес төлөвлөгөөгөө боловсруулж, хөрөнгө оруулалтаа босгон, компани байгуулах үйл явцыг багтаасан арга хэмжээ юм.

“Pitch event” ээс шалгарсан нэг гарааны бизнес санхүүгийн дэмжлэг авна, үүнээс гадна аймаг орон нутгийн захиргаа ажил олгогчдоос дэмжлэг авна. Шалгараагүй бусад оролцогчид мөн бизнес санаагаа хөгжүүлэх, бизнес төлөвлөгөөгөө боловсруулах, баг бүрдүүлэх, хөрөнгө босгох гэх мэт бизнес эрхлэлт, энтрэпренёршипийн маш чухал мэдлэг, чадваруудыг эзэмших боломжтой.

Энэхүү арга хэмжээ нь залуучуудыг гарааны бизнес эрхлэх, бүтээлч сэтгэхүйтэй болгох, сурган хүмүүжүүлэх, онолоор эзэмшсэн мэргэжлээ практикт турших, өөрийгөө илэрхийлэх, санаагаа хөгжүүлэх, бүтээгдэхүүнээ борлуулах, бизнесээ төлөвлөх, амжилтын төлөө тэмцэх зэрэг олон талын ач холбогдолтой арга хэмжээ юм.

Арга хэмжээнд оролцсон залуучуудад бизнесийн сургалт зохион байгуулагдсаны дараа гарааны бизнесийн арга хэмжээ дараах загвар хөтөлбөрөөр явагдана.

Өдөр I	Өдөр II	Өдөр III
17:30 Бүртгэл	09:00 Цуглах, өглөөний цай	09:00 Цуглах, өглөөний цай
19:00 Оройн хоол, танилцах	09:30 Багаар хуваагдан менторууд - тай ажиллах	10:00 Асуулт, хариулт
19:00 Бизнес санаа танилцуулах	12:00 Өдрийн хоол	11:00 Зөвлөхүүд багуудад туслах
20:00 Санал хураах	13:00 Зөвлөхүүдийн танилцуулга	14:00 Өдрийн хоол
20:30 Багт хуваагдах	14:00 Зөвлөхүүд багт туслах	15:00 Багууд танилцуулга хийхэд бэлдэх
21:00 Багуудад зааварчилгаа өгч, хэрэгцээт материалуудаар ханган ажилд нь оруулах	14:30 Багууд ажиллана	17:00 Багуудын төслийн танилцуулга
	18:30 Оройн хоол	18:00 Шүүлт
	19:30 Явцын тайлан, тусламж үзүүлэх	19:30 Шагнал гардуулах ёслол
	22:00 Ажлаа дуусгана	20:00 Хаалт

Үйл ажиллагааны ерөнхий агуулга

Elevator Pitch / Бизнес санаагаа хөрөнгө оруулагчид танилцуулах

Ideation / Team Formation буюу баг болох , бизнес санаа дээр багаа бүрдүүлэх

Customer Discovery / Development буюу хэрэглэгчээ олох, санаа хөгжүүлэх

Business Model Generation/ Бизнес загвараа бий болгох

Хурдасгуур хөтөлбөр:

Питч (pitch) арга хэмжээнээс шалгарсан багийг 5 долоо хоногийн бизнесийн хурдасгуур хөтөлбөрт хамруулна. Хөтөлбөр нь туршилтын загвар схемд заасан хөтөлбөрийн дагуу явагдана. Хурдасгуур хөтөлбөрт амжилттай хамрагдаж бүтээгдэхүүний энгийн загварыг гаргаж хэрэглэгчээр туршуулсаны дараа эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгоно.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.7, 28 дугаар зүйлийн 28.8.2, Засгийн газрын 2011 оны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 4.6, 4.7-д заасныг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг хоёрдугаар, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийг гуравдугаар, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг дөрөвдүгээр, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг тавдугаар, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг зургаадугаар хавсралтаар баталж, 2017-2018 онд хэрэгжүүлсүгэй.
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг хуваарилан, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т, хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/-т тус тус даалгасугай.
3. “Засгийн газар болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад хөтөлбөр, төслийн санхүүжилт”-ээр хэрэгжүүлэх төслүүдийн тэргүүлэх чиглэлийг батлуулахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/-т, батлагдсан чиглэлийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгохоор төрийн болон төрийн бус байгууллагуудын санаачилсан төслүүдийг сонгон шалгаруулж, шийдвэрлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

*Үндэсний зөвлөлийн дарга,
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайд*

Н.НОМТОЙБАЯР

*Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн
дарга*

Д.ХАДХҮҮ

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн
хурлын нэгдүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

Залуучууд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийг аж ахуй, бизнес эрхлэх ур чадвар, шинэлэг санаанд тулгуурлан гарааны болон санхүүгийн дэмжлэг олгох, бизнесээ тогтвортой эрхлэхийг дэмжих арга хэмжээнд хамруулж байнгын ажлын байртай болгох замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Хөтөлбөрт залуучууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид хэрэгжүүлэх арга хэмжээний шаардлагын дагуу хамрагдана.

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

3.1.1. Гарааны бизнесийг дэмжих;

3.1.2. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох;

3.1.3. Борлуулалтын болон үйлдвэрлэлийн ажлын байрны түрээсийн хөнгөлөлт олгох.

Дөрөв. Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг туршилтаар² зохион байгуулах

4.1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс³ нь гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

4.1.1. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих ажлын хэсгийг⁴ аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, Төсөл хэрэгжүүлэх нэгж \ГХН\ болон холбогдох төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.1.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс болон сум, хорооны хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь гарааны бизнес эхлүүлэх хүсэлтэй залуусыг⁵ бүртгэж, бүлэг байгуулна.

4.1.3. Уг бүлгийн гишүүдэд гарааны бизнесийн таатай орчин бүрдүүлэх талаар сургалт, дараагийн шатанд аж ахуй эрхлэлт, бизнес загвар боловсруулах сэтгэлгээний сургалт⁶ зохион байгуулна.

² ШХА-ийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд Төсөл хэрэгжүүлэх нэгж хамтран зохион байгуулж, хэрэгжүүлнэ. Төсөл хэрэгжүүлж буй: Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Завхан, Өмнөговь, Увс, Ховд аймгууд ба нийслэлийн Баянгол, Хан-Уул дүүрэг хамаарна.

³ Туршилтаар хэрэгжүүлэх арга хэмжээг 2017 онд төсөл хэрэгжиж буй аймаг, дүүрэгт зохион байгуулж туршлага, сургамжид тулгуурлан зохистой загварыг бий болгон улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлнэ.

⁴ Ажлын хэсгийн ажлын нийтлэг удирдамжийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батална.

⁵ 15-34 насны залуучууд байна.

⁶ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын жишиг хэмжээ”-нээс хэтрүүлэхгүй.

- 4.1.4. Гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх, багаар ажиллаж ирээдүйтэй санааг бизнесийн зөвлөх (ментор)-ийн туслалцаатайгаар хөгжүүлэх, шилдэг гарааны бизнесийг сонгон шалгаруулах 54 цагийн арга хэмжээг Ажлын хэсэг, сум, хорооны гарааны бизнесийг дэмжих бүлгийн гишүүд бизнесийн зөвлөхүүдтэй хамтран зохион байгуулна.
- 4.1.5. Залуучуудад аж ахуй эрхлэлт, загвар бүтээх сэтгэлгээний сургалт, гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх зөвлөгөөг бүлгүүдийн хэрэгцээ, хүсэлтэд үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дэргэдэх бизнес инкубатор төв, эсвэл мэргэшсэн, эрх бүхий байгууллага⁷ ын туслалцаатайгаар зохион байгуулж, холбогдох зардлыг санхүүжүүлж⁸ болно. Шалгарсан нэг төсөлд 10,0 сая төгрөгийн гарааны дэмжлэгийг 24 сарын хугацаатайгаар олгоно.
- 4.1.6. Гарааны бизнесийг сонгон шалгаруулахад эхний байранд шалгарсан багтай Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс гарааны дэмжлэг олгох тухай гэрээ байгуулж, хамтран ажиллах ба төсөл хэрэгжүүлэх эхний 6 сард гарааны дэмжлэгийн эргэн төлөлт хийхгүй байж болох ба эргэн төлөлт⁹ ийн хуваарийг бүлгийн саналд үндэслэн тогтооно.
- 4.1.7. Санхүүгийн дэмжлэгийг гарааны бизнес эрхлэх хүний цалин хөлсөнд болон шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эргэлтийн хөрөнгө гэх мэт гэрээнд заасан зориулалтаар зарцуулна.
- 4.2. Туршилтаар хэрэгжүүлэх арга хэмжээг 2017 онд төсөл хэрэгжиж буй аймаг, дүүрэгт зохион байгуулж туршлага, сургамжид тулгуурлан зохистой загварыг бий болгон улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлнэ.
- 4.3. Энэхүү арга хэмжээг төсөл хэрэгжээгүй¹⁰ аймаг, нийслэлийн дүүргүүд хэрэгжүүлэх бол гарааны бизнесийг дэмжих үйл ажиллагааг зохих дараалал, зарчмын дагуу зохион байгуулах ба ТХН-тэй хамтран сургагч багш, зөвлөхүүдийг бэлтгэсний дараа хэрэгжүүлж болно. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь уг арга хэмжээг аймаг, дүүрэгт хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн гэж үзвэл нэмэлт санхүүжилтийг хуваарилна.

Тав. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүлэгт санхүүгийн дэмжлэг олгох

- 5.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгч¹¹-ийг хувиараа болон бүлгээр хөдөлмөр эрхэлж, ажлын байр бий болгох зорилгоор тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад нь зориулж, нэг төгсөгчид 3 сая төгрөг, бүлэгт 10 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгоно. Төгсөгчид бүлэг болсон тохиолдолд 5-аас ихгүй гишүүнтэй байна.

⁷ Гарааны бизнесийг дэмжих мэргэшсэн байгууллага, бизнес инкубатор болон бизнесийг дэмжих төвүүдийн жагсаалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар гаргана.

⁸ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын жишиг хэмжээнээс хэтрүүлэхгүй.

⁹ Гарааны дэмжлэгийн эргэн төлөлтийг аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлж зохих журмын дагуу хяналт тавьж ажиллана.

¹⁰ Нийслэлийн Хан-уул, Баянгол дүүргээс бусад дүүрэгт хамаарна.

¹¹ 15-24 насны залуучууд байна.

- 5.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүлэг нь бизнес, аж ахуй эрхлэх талаарх төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт, холбогдох мэдээллийг боловсруулж, төгсөгчийн болон бүлгийн ахлагчийн байнга оршин суух хаягийн бүртгэлээр харьяалах Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүсэлт гаргана.
- 5.3. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь 3, 8 дугаар саруудад төгсөгчдийн төслийг зарлах, төслүүдийн хэрэгжих үндэслэлийг тооцон шалгаруулж, гэрээ байгуулан хамтран ажиллана.
- 5.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног, төхөөрөмж, багаж хэрэгслийг худалдан авах ажилд төгсөгч болон төгсөгчдийн бүлэгт арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллана.
- 5.5. Төгсөгч болон бүлэг нь гэрээ байгуулснаас хойш 24 сарын дотор санхүүгийн дэмжлэгийг эргүүлэн төлөх ба эргэн төлөлтийн хуваарийг төгсөгч, бүлгийн саналыг харгалзан тогтооно.
- 5.6. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагч, төгсөгч нь үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй ажил, мэргэжлийн уралдаан, тэмцээнд амжилт гарган шилдгээр шалгарсан тохиолдолд мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад дэмжих багаж, тоног төхөөрөмж авахад зориулан олгох урамшууллыг батламж, гэрчилгээнд үндэслэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас санхүүжүүлж болно.
- 5.7. Төслийн шалгаруулалтын дүн шийдвэрийн талаар олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, шалгаруулалттай холбоотой гарсан маргааны асуудлыг бүрэн хариуцан хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 5.8. Төгсөгч болон төгсөгчдийн бүлэг нь бизнес, аж ахуй эрхлэх зориулалтаар авсан дэмжлэгийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон нөхцөлд уг дэмжлэгийн хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд нэн даруй эргэн төлүүлнэ.

Зургаа. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүлэгт борлуулалтын болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах

- 6.1. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх санхүүгийн болон гарааны дэмжлэг авсан залуучууд, залуучуудын бүлгийг бараа, бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх, ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 6.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь бараа, бүтээгдэхүүнийг борлуулах төвлөрсөн цэгийг ажиллуулна¹².
- 6.3. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар байнгын ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа бол түрээсийн гэрээ, холбогдох баримт бичиг, нөхцөл байдлыг газар дээр нь үнэлсэн үнэлгээнд

¹² Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан "Борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ"-нээс хэтрүүлэхгүй байна.

- үндэслэн ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг¹³ төлбөр төлсөн баримтаар нөхөн олгоно.
- 6.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг зарж борлуулахад чиглэсэн үзэсгэлэн, яармагийг зохион байгуулна.
- 6.5. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь үндэсний бүтээгдэхүүнийг гадаад орнуудад гаргаж, борлуулалт хийдэг байгууллагуудаар дамжуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг гадаад орнуудад борлуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 6.6. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын www.hudulmur-halamj.mn цахим хуудсанд энэхүү хөтөлбөрт хамрагдсан залуучуудын бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах тусгайлсан нэмэлт цэс ажиллуулж, борлуулалтад дэмжлэг үзүүлж, тус цэсийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.
- 6.7. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь тусгайлсан нэмэлт цэсэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдан санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн бараа, бүтээгдэхүүний мэдээллийг сар бүр шинэчлэн оруулна.
- 6.8. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан бол 24 сарын хугацаанд энэхүү хөнгөлөлтөд дахин хамруулахгүй.
- 6.9. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдаж буй төгсөгч болон төгсөгчдийн бүлгийн хэрэгцээ, хүсэлтэд үндэслэн аж ахуй эрхлэлтийн сургалт, зөвлөгөө өгөх, үйлдвэрлэлийн байр түрээслүүлэх арга хэмжээг Улаанбаатар хотод Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, орон нутагт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь эрх бүхий байгууллагуудтай¹⁴ гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж болно.
- 6.10. Бизнес эхлэх, хөгжүүлэх, аж ахуй эрхлэх төлөвлөгөө, төсөл боловсруулах, гарааны бизнесийг хөгжүүлэх, хоршоо, нөхөрлөл, бүлэг байгуулж үйл ажиллагаа эрхлэх, борлуулалтын сүлжээ, маркетингийн болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээрх сургалтын хөтөлбөрөөс сонгон аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдана.
- 6.11. Аж ахуй эрхлэлтийн сургалтын үргэлжлэх хугацаа ажлын 3 болон 5 хоног байх бөгөөд 3 хоногийн сургалт нь 21-ээс, 5 хоногийн сургалт нь 36-гаас доошгүй цагийн хөтөлбөртэй байна.
- 6.12. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөтөлбөрт хамрагдсан залуучуудын үйл ажиллагааг дэмжих, хэрэгжилтийн явцад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах ба хяналт тавих, хэрэгжүүлж буй арга хэмжээг сайжруулах зорилгоор залуучууд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд, ажил олгогчдын оролцоотой туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгийг жилд 2 удаа зохион байгуулж болно.

¹³ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан “Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ”-нээс хэтрүүлэхгүй байна.

¹⁴ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь эрх бүхий бизнес инкубатор төв, мэргэшсэн сургалтын байгууллагуудын жагсаалт гаргана.

Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

7.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

- 7.1.1. Гарааны бизнесийг дэмжих бүлгийн гишүүдийн тоо, үйл ажиллагааны салбараар, нас, хүйсээр;
- 7.1.2. Гарааны бизнесийг дэмжих бэлтгэгдсэн сургагч багшийн тоо, нас, хүйсээр;
- 7.1.3. Санхүүгийн дэмжлэг авсан баг, төгсөгчдийн тоо, үйл ажиллагааны салбараар, нас, хүйсээр;
- 7.1.4. Борлуулалтын болон түрээсийн төлбөрийн хөнгөлөлт, сургалтад хамрагдсан баг, хүмүүсийн тоо, үйлчилгээний чиглэл тус бүрээр, нас, хүйсээр;
- 7.1.5. Шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж, бизнесийн бүлгийн тоо, шинээр бий болсон ажлын байрны тоо.

7.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

- 7.2.1. Залуучуудын аж ахуй, бизнес, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна;
- 7.2.2. Залуучуудын гарааны бизнес, санхүүгийн дэмжлэгийн үр ашиг дээшилсэн байна.

-----o0o-----

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 5 дугаар
сарын 02-ны өдөр

А/106

Улаанбаатар
хот

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг
хэрэгжүүлэх ажлын удирдамж, зөвлөмж батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10.3 дахь хэсгийг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын тогтоолоор 5.4.3 Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн 4.1.1. дэх заалтуудын хэрэгжилтийг хангах зорилгыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрхийн бичгээр хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах удирдамж"-ийг нэгдүгээр, "Залуучуудын гарааны бизнесийг дэмжих ажлын хэсгийн үйл ажиллагааны нийтлэг зөвлөмж"-ийг хоёрдугаар, "Ажил хайгч иргэн, оюутан, суралцагчдийг цагийн ажилд зуучлах зөвлөмж"-ийг гуравдугаар, "Мэргэжлийн мэдээллийн жишиг үйлчилгээ үзүүлэх зөвлөмж"-ийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд заасан үйл ажиллагааны удирдамж, зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг хангах, ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газрын дарга /Ч.Саналбаяр/-д даалгасугай.

ДАРГА

Б.НЯМДАВАА

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 02 өдрийн А/106 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих ажлын хэсэг (Цаашид "ажлын хэсэг" гэх) нь залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд залуучуудын гарааны бизнесийг дэмжих үйлчилгээг аймаг, нийслэл дүүргийн хэмжээнд зохион байгуулж ажиллахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, шинэлэг бизнес санааг дэмжихэд хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдийн оролцоо, санаачилгыг өрнүүлэх, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй ажиллана.
- 1.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтсийн даргын тушаалаар батална.
- 1.3. Ажлын хэсэг дараах бүрэлдэхүүнтэй байна.
 - 1.3.1. Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг хэлтэс/албаны дарга
 - 1.3.2. Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлд төрийг төлөөлж буй төсөв, санхүү, хөрөнгө оруулагч байгууллагуудын төлөөлө;
 - 1.3.3. Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлд ажил олгогчийг төлөөлж буй ажил олгогчдын байгууллагууд төлөөлөл;
 - 1.3.4. Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтэс/албаны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүд;
 - 1.3.5. Бизнесийн хөгжлийг дэмжих төрийн бус байгууллагын төлөөлө (Харилцан тохиролцооноор)
 - 1.3.6. Шинэлэг гарааны бизнесийг дэмжих төрийн бус байгууллагын төлөөлөл (Харилцан тохиролцооноор)
- 1.4. Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс/албаны дарга нт ажлын хэсгийн ахлагчийн, уг хэлтэс/албаны залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн нь ажлын хэсгийн нарийн бичгийн даргын үүргийг тус тус гүйцэтгэнэ.

Хоёр. Ажлын хэсгийн үүрэг, үйл ажиллагаа

- 2.1. Ажлын хэсэг дараах үүрэг гүйцэтгэнэ.
 - 2.1.1. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих асуудлаар мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангах
 - 2.1.2. Аймаг, нийслэл, дүүрэгт гарааны бизнесийг дэмжих санаачилга, хөдөлгөөн өрнүүлэх, санаачлагчдын хурал, зөвлөгөөн хийхэд дэмжлэг

- үзүүлэх, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын дэмжлэг авах ажлыг зохион байгуулах
- 2.1.3. Сум, хооронд гарааны бизнесийг дэмжих бүлэг байгуулахад дэмжлэг үзүүлэх
 - 2.1.4. Аймаг, нийслэл, дүүрэг дэх хөрөнгө оруулагчил, бизнес эрхлэгчид, бизнесийн хөгжлийг дэмжих байгууллага, бизнесийн зөвлөхүүдийн оролцоо, хамтын ажиллагааг гарааны бизнесийг дэмжихэд чиглүүлэх
 - 2.1.5. Гарааны бизнесийг эхлүүлэх хүсэлтэй залуучуудын бүлэгт гарааны бизнес, аж ахуй эрхлэлт, загварчлах сэтгэлгээ, бизнес загвар боловсруулалтын сургалт зохион байгуулж, хяналт тавих
 - 2.1.6. Гарааны бизнесийг эхлүүлэх хүсэлтэй залуучууд бизнес санаагаа танилцуулах, ирээдүйтэй бизнесийн санааг шалгаруулах, багаар ажиллаж бизнесийн зөвлөх (ментор)-ийн туслалцаатайгаар гарааны бизнес загвар боловсруулж бэлтгэх, гарааны шилдэг бизнесийг сонгон шалгаруулах 54 цагийн арга хэмжээг мэргэшсэн, туршлагатай, байгууллагын туслалцаатайгаар зохион байгуулах
 - 2.1.7. Залуучуудын гарааны шилдэг бизнесээр шалгарсан багуудыг бизнес хурдасгуурын сургалтанд хамруулах ажлыг холбогдох төсөл, байгууллагаас зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх
 - 2.1.8. Аймаг, нийслэл, дүүргийн түвшинл гарааны шилдэг бизнесээр шалгарсан багуудад гарааны бизнес эхлэх дэмжлэг үзүүлэх ажлыг аймаг, нийслэл дүүрэг дэх хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчид, бизнесийн хөгжлийг дэмжих ббайгууллагуудтай хамтран зохион байгуулж, хяналт тавин ажиллах
 - 2.1.9. Гарааны бизнесийг дэмжих хүрээнд дэмжлэг авсан залуучууд бараа, бүтээгдэхүүнээ борлуулах, ажлын байрны түрээслэхэд дэмжлэг, хөнгөлөлт авч байгаа байдалд хяналт тавих
 - 2.1.10. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүтэгт арга зүйн дэмжлэг үзүүлэх, шаардлага хангаж буй тохиолдолд энэхүү удирдамжийн 2.1.5-2.1.7-д заасан арга хэмжээнд хамруулах

2.2 Ажлын хэсгээс явуулах үйл ажиллагаа

- 2.2.1 Ажлын хэсгийн үйл ажиллагааны үндэс хэлбэр нь хурал байна. Ажлын хэсгээс гаргасан шийдвэр, мэдээллээ олон нийтэд мэдээлнэ.
- 2.2.2 Шаардлагатай тохиолдолд ажлын хэсгийн хурлыг өргөтгөсөн байдлаар хийж болно. Энэхүү өргөтгөсөн хуралд оролцогчдын жагсаалтыг ажилын хэсгийн нарийн бичгийн дарга боловсруулж ажилын хэсгийн даргад танилцуулж батлуулна.
- 2.2.3. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хурлын явцын талаар тэмдэглэл хөтөлж, ажлын хэсгийн даргад хянуулан гарын үсэгзурруулж баталгаажуулна.

- 2.2.4. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь хурлаас гаргасан шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад шуурхай хүргэнэ.
- 2.2.5 Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж оны эцэст хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн хурал танилцуулна.

-----o0o-----

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 9 дүгээр
сарын 19-ны өдөр

А/242

Улаанбаатар
хот

Гарааны бизнесийг дэмжих загварыг туршилтаар
хэрэгжүүлэх удирдамж батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2017 оны “ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг батлах тухай “01 тоот тогтоолын 2 дахь заалт, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн Тушаах нь :

1. Гарааны бизнесийг дэмжих загварыг туршилтаар хэрэгжүүлэх удирдамжийг нэгдүгээр, Гарааны бизнесийг дэмжих, хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах сургалтын жишиг хөтөлбөрийг хоёрдугаар, Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний зардлын жишиг хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг зохион байгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газрын дарга /Ч.Саналбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.НЯМДАВАА

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 9 дүгээр сарын 19 өдрийн А/242 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ЗАГВАРЫГ ТУРШИЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Залуучуудыг аж ахуй, бизнес эрхлэх ур чадвар, шинэлэг санаанд тулгуурлан гарааны дэмжлэг олгох, бизнесээ тогтвортой эрхлэхийг дэмжих арга хэмжээнд хамруулж байнгын ажлын байртай болгох замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зохистой загварыг бий болгох турших, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулахад удирдамжийн зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. 15-34 насны гарааны бизнес эрхлэх хүсэлтэй залуучууд

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ, үе шат

3.1. **Нэгдүгээр үе шат.** Бүртгэл, сургалтын арга хэмжээг зохион байгуулах

3.1.1. Гарааны бизнес эрхлэх хүсэлтэй залуусыг¹⁵ бүртгэж сонгон шалгаруулна.

3.1.2. Шалгарсан гарааны бизнес эрхлэх хүсэлтэй залуучуудыг доорх төрлийн сургалтуудад хамруулна. Үүнд:

3.1.3. Бизнесийн санаа, бизнесийн санаагаа хөгжүүлэх оролцоонд тулгуурласан сургалт

3.1.4. Бизнес загвар боловсруулах сэтгэлгээний сургалт/Загварчлах сэтгэлгээ/

3.1.5. “Бизнес модель хавтан” ашиглах сургалт

3.2. **Хоёрдугаар үе шат.** Гарааны бизнесээ эхлүүлэх/Startup Weekend/ арга хэмжээг хэрэгжүүлэх

3.2.1. Гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх, багаар ажиллаж ирээдүйтэй санааг бизнесийн зөвлөх/ментор/-ийн туслалцаатайгаар хөгжүүлэх, шилдэг гарааны бизнесийг сонгон шалгаруулах 54 цагийн арга хэмжээг зохион байгуулна.

3.2.2. Энэхүү арга хэмжээг эрх бүхий мэргэшсэн байгууллагуудын оролцоотойгоор зохион байгуулж шалгаруулалтыг хийнэ. Шалгарсан нэг төсөлд 10,0 /арван/ сая төгрөгийн гарааны эргэн төлөгдөх нөхцөлтэй дэмжлэгийг олгоно.

3.3. **Гуравдугаар үе шат.** Бэлтгэл хурдасгуур/Pre-Accelerator/ арга хэмжээг хэрэгжүүлэх

3.3.1. Шалгарсан багуудын гарааны бизнесийг бизнесийн зөвлөх /ментор/-ын туслалцаатайгаар 5 долоо хоногийн турш хөгжүүлэх, бойжуулах,

¹⁵ 15-34 насны залуучууд байна.

тэдгээрийг тогтсон бизнес эрхлэгч болгон хувиргах хөтөлбөрийг эрх бүхий мэргэшсэн байгууллагатай хамтран зохион байгуулна.

3.4. Дөрөвдүгээр үе шат. Хөрөнгө оруулагчид, олон нийтэд төслөө танилцуулах өдөр/Demo Day/ арга хэмжээг хэрэгжүүлэх

3.4.1. Бэлтгэл хурдасгуур хөтөлбөрт амжилттай оролцсон гарааны бизнес эрхлэгчдийг хөрөнгө оруулагчидтай холбох, санхүүжилтийг татах, хөрөнгө оруулах, хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээг зохион байгуулна.

**Дөрөв. Гарааны бизнесээ эхлэх /Startup Weekend /
арга хэмжээг зохион байгуулах**

- 4.1. Нэгдүгээр үе шатны сургалтанд хамрагдсан гарааны бизнес эрхлэх хүсэлтэй залуучууд Гарааны бизнесээ эхлэх арга хэмжээнд оролцоно.
- 4.2. Гарааны бизнесээ эхлэх 54 цагийн сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулна.
- 4.3. Гарааны бизнес эрхлэх хүсэлтэй залуучууд бизнесийн зөвлөхүүдээс/ментор/ өөрийн бизнесийн санааг хөгжүүлэхэд хэрэгтэй зөвлөгөөг авна.
- 4.4. Гарааны бизнесээ эхлэх 52 цагийн арга хэмжээний дараа шүүгчид шүүлт хийж хамгийн шилдэг багуудыг тодруулна.

Тав. Бэлтгэл хурдасгуур / Pre-Accelerator / арга хэмжээг зохион байгуулах

- 5.1. Гарааны бизнесээ эхлэх арга хэмжээнээс шалгарсан багуудыг бизнесийн бэлтгэл хурдасгуур арга хэмжээнд хамруулна. Тус арга хэмжээний хүрээнд дараах сургалтуудыг зохион байгуулна. Үүнд:
 - Хурдасгуур хөтөлбөрийн танилцуулга
 - Хэрэглэгчийн хөгжил/Зах зээл, бараа бүтээгдэхүүний нийцэл, туршилтын бүтээгдэхүүн, хэрэглэгчийн баталгаажуулалт/
 - Бизнес модель үүсгэх /Бизнес модель хавтан, Петер Тил-н 7 асуулт/
 - Загварчлах сэтгэлгээ /Ойлгох, Тодорхойлох, Санаачлах, Туршилтын бүтээгдэхүүн, Турших/
 - Гарааны бизнесийн санхүү /Хөрөнгө оруулалтын бүтэц, хөрөнгө оруулалтын үе шат/
 - Хөрөнгө оруулалтын танилцуулга бэлтгэх - /Зах зээлээ хэмжих/

**Зургаа. Хөрөнгө оруулагчид, олон нийтэд төслөө танилцуулах
/Demo Day/ арга хэмжээг зохион байгуулах**

- 6.1. Бэлтгэл хурдасгуур арга хэмжээнд хамрагдсан багууд хөрөнгө оруулагчид болон олон нийтэд өөрсдийн гарааны бизнесийг танилцуулна.
- 6.2. Сонгогдсон багууд 3-5 минутын хугацаанд хөрөнгө оруулагч, зочид болон шүүгчдийн өмнө санаагаа танилцуулах бөгөөд бизнесийн тохиролцоо хийх боломж олгоно.

Долоо. Хүрэх үр дүн

7.1. Хүрэх үр дүн

- 7.1.1. Орон нутагт гарааны бизнес, энтрепренершип¹⁶-ийн экосистем төлөвшсөн байна.
- 7.1.2. Гарааны бизнесийг дэмждэг төрийн болон төрийн бус байгууллагууд хувийн хэвшил, хувь хүмүүс, сайн дурынхан чадавхиж, сайн дурын бүлгэм үүсч, цаашид тогтвортой бүтэцтэй болсон байна.
- 7.1.3. Орон нутагт залуучуудын энтрепренершип, гарааны бизнесийн соёл төлөвшиж, гарааны бизнес эрхлэх дадал, сэтгэхүйтэй болсон байна.
- 7.1.4. Ажлын байрыг бий болгох бодит гарааны бизнес үүссэн байна

-----oOo-----

¹⁶ Маш гайхалтай санааг аваад амжилттай ажил хэрэг болгох хүртэлх бүхий л саад бэрхшээлийг даван туулж, хөдөлмөрлөж амжилтад хүртэл удирдан явах үйл явцыг хэлнэ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 9 дүгээр сарын 19-ны өдрийн А/242 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ, ХӨГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨРҮҮД

А. ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Зорилго: Залуучуудад гарааны бизнесийг хөгжүүлэх талаар системтэй мэдлэг олгох, гарааны бизнесийг хөгжүүлэх ур чадвар эзэмшүүлэх, бизнесээ тогтвортой эрхлэхийг дэмжих

Оролцогчдод тавигдах шаардлага:

- Хувиараа болон бүлгээрээ бизнес хийх сонирхолтой
- Бизнес төсөл, төлөвлөгөө боловсруулах туршлага, ур чадвартай бол давуу талтай
- Тодорхой бизнесийн салбарын туршлага, мэдлэгтэй

Хамрах хүрээ: 15-34 насны залуучуудыг оролцуулна. */Хувь хүн болон багаараа оролцох боломжтой/*

Оролцогчдыг сонгох шалгуур:

- Өөрсдийн бизнес санааны талаар товч танилцуулгыг явуулна. */Хувь хүн болон багийн, бизнес санааны товч танилцуулга/*
- Баг болсон тохиолдолд 5-аас ихгүй гишүүнтэй байна.

Сургалтын хугацаа: 3 өдөр

Сургалтын хуваарь:

Эхний өдөр	
09:00 ~ 09:30	Хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаа
09:30 ~ 10:30	Гарааны бизнесийн төрлүүд, энтрепренершипийн талаар ерөнхий ойлголт
10:30 ~ 11:15	Цагаан идээ, оёдол, нэхмэл, гар урлалын чиглэлийн гарааны бизнесийн бодит кейс жишээ, шинэ санаанууд
11:15 ~ 11:30	Цайны завсарлага
11:30 ~ 12:15	Оролцогчдын бизнес санааны танилцуулга
12:15 ~ 13:00	Баг бүрдүүлэлт, зөвлөхүүдийн танилцуулга
13:00 ~ 14:00	Үдийн хоол
14:00 ~ 14:45	Бизнес санаанд оношлогоо хийх
14:45 ~ 15:30	Бизнес санааг шинжилж, оношлох / Багаар ажиллах дасгал /
15:30 ~ 16:15	Бизнес санааг шинжилж, оношлох / Багаар ажиллах дасгал /
16:15 ~ 16:30	Цайны завсарлага
16:30 ~ 18:00	Бизнесийн загварын сургалт/Менторын зөвлөгөө, сургалт/

Хоёрдахь өдөр	
09:00 ~ 09:45	Өглөөний цай
09:45 ~ 11:15	Өөрсдийн бизнесийн загвараа гаргах
11:15 ~ 11:30	Цайны завсарлага
11:30 ~ 13:00	Менторын зөвлөгөө, сургалт
13:00 ~ 14:00	Үдийн хоол
14:00 ~ 14:45	Хөрөнгө босголтын хэлбэрүүд
14:45 ~ 16:15	Хөрөнгө оруулагчдын анхаарлыг хэрхэн татах вэ?
16:15 ~ 16:30	Цайны завсарлага
16:30 ~ 17:15	Хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулгыг хэрхэн бэлтгэх вэ?
Гуравдахь өдөр Demo day	
09:00 ~ 09:45	Өглөөний цай
09:45 ~ 12:00	Асуулт, хариулт
12:00 ~ 13:00	Өдрийн хоол
13:00 ~ 13:30	Зөвлөхүүд багт зөвлөгөө өгнө.
13:00 ~ 14:00	Багуудын үйл ажиллагаа
14:00 ~ 15:30	Багуудын үйл ажиллагаа
15:30 ~ 16:15	Төслийн танилцуулга бэлтгэх
16:15 ~ 17:30	Багуудын танилцуулга / орон нутгийн болон салбарын онцлог /
17:30 ~ 18:00	Багуудын танилцуулга / зорилтот бүлгүүдийн онцлог /
18:00 ~ 19:00	Дүгнэлт

Б. Сумын залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр

Онцлох сэдвүүд :

- Орон нутгийн хөгжлийн боломж-гарц
- Өрхийн аж ахуй эрхлэлт ба уламжлалт аж ахуйн хөгжил, тэргүүн туршлага арга барил өвлөх асуудлууд
- Байгаль орчин- эрсдлийн нөхцөл байдлыг даван туулах чадвар
- Орон нутгийн үйлдвэрлэлийг Дайманд, үнэ цэнийн сүлжээний аргаар шинжлэх нь
- Орон нутаг дахь хөрөнгө босголтын хэлбэрүүд

В. МСҮТ-ийн төгсөгч, суралцагчдын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр

Онцлох сэдвүүд:

- Хөдөлмөрт бэлтгэх үнэлгээний аргууд – профайлинг үйлчилгээ
- Хувьсан өөрчлөлтийн орчинд гарааны бизнесийг амжилттай хөгжүүлэх шийдлийн аргууд
- Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд бий болгох – дизайн загварууд
- Бизнес санааг шинжлэх, оношлох аргууд
- Хөрөнгө босголтын хэлбэрүүд

Г. Малчдын аж ахуй эрхлэлтийг дэмжих гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр

Онцлох сэдвүүд:

- Мал аж ахуй маркетинг , орон нутгийн бренд бүтээх
- Мал ахуй үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог - байгаль орчины нөлөөлөл, эрсдэлээс хамгаалах
- Мал маллагааны тэргүүн туршлага ба инноваци, мэдээллийн технологийн дэвшилтэт арга хэлбэрүүд
- Бизнес санааг шинжлэх, оношлох аргууд
- Хөрөнгө босголтын хэлбэрүүд
- Д. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих загвар хөтөлбөр

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд хэрэгжиж буй хөтөлбөр 3 үе шатаас бүрдэнэ. Үүнд:

1 дүгээр үе шат

- Орон нутагт дэмжих багийг бий болгох
- Гарааны бизнесийн экосистемийг бий болгох
- Бүртгэл, шалгаруулалтын шаардлагууд
- Сургалт – загварчлах сэтгэлгээний сургалт , бизнес модель хавтангийн сургалт

2 дугаар үе шат

- Бизнес санааны танилцуулга
- Баг бүрдүүлэлт
- Санаагаа баталгаажуулах
- Төслийн удирдлага ба шалгаруулалт

3 дугаар үе шат

- Хурдасгуур хөтөлбөр /аскелаторийн хөтөлбөр/
- Хөрөнгө оруулалтыг татах уулзалт арга хэмжээ

-----o0o-----

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 9 дүгээр сарын 19-ны өдрийн А/242 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ЖИШИГ ХЭМЖЭЭ

Д/Д	Зардлын хэмжээг жишиг болгох арга хэмжээнүүд	Зардлын төрөл, хэмжээ
1.	Аж ахуй эрхлэлтийн сургалтууд Бизнес санааг хөгжүүлэх Бизнес сэтгэлгээг хөгжүүлэх Бизнес модел хавтан	Нэг хоногийн сургалтын дээд хэмжээ Нэг оролцогчид- 5000 төгрөг
2.	Зөвлөх үйлчилгээ /ментор зөвлөх болон багш, чиглүүлэгч, зохион байгуулагч нарын цагийн ажлын хөлс/	Нэг цагийн ажлын хөлс - 3500 төгрөг
3.	Оролцогчдын үйл ажиллагааны дэмжлэг	Түрээсийн төлбөрийн нэг хоногийн зардлын дээд хэмжээ Дүүрэгт-8300 төгрөг Аймгийн төвд- 6600 төгрөг Сумын төвд- 5000 төгрөг Хоолны зардал нэг оролцогчид хоногт- 5000 төгрөг Сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн зардал нэг оролцогчид- 6000 төгрөг
4.	Шалгаруулалтын үйл ажиллагааны дэмжлэг	Шалгарсан төсөлд 10,0 сая төгрөг
	Шалгаруулалтанд бэлтгэх үйлчилгээ /зар сурталчилгаа, бүртгэл, мэдээллийн сүлжээ ажиллуулах, нэгдсэн хувцаслалт г.м /	Нэг оролцогчид - 45000 төгрөг



ХӨДӨЛМӨР,
НИЙГЭМ ХАМГААЛЛЫН ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



Youth Startup Program

Залуучуудын гарааны бизнесийг дэмжих загвар схем

Гарааны бизнес, энтрепренершипийн хөгжлийн олон улсын туршлага, Монгол улсад энэ чиглэлээр явуулж буй үйл ажиллагаа, бодлого эрх зүйн орчны хүрээнд судалгаа явуулсны үндсэн дээр хот болон орон нутагт залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.



Youth Startup Program

Хамрах хүрээ

(Аймаг, дүүрэгт зохион байгуулагдана.)

- Баянгол
- Хан-Уул
- Дархан
- Өмнөговь
- Баянхонгор
- Говь-Алтай
- Завхан
- Ховд
- Увс
- Баян Өлгий



YOUTH EMPLOYMENT PROJECT



20 гаруй хүнтэй баг

Орон нутгийн гарааны бизнесийг дэмжих баг



50 оролцогч


Нийт оролцох хүсэлт гаргасан хүмүүс өөрийн бизнес санааны талаар 1 минутын танилцуулга видео илгээнэ. Эндээс шалгарсан залуучууд хөтөлбөрт оролцох эрхтэй болно.

Сургалтанд хамрагдсан залуу энтрепренёруудыг 54 цагийн турш вакумжуулан, бизнес санааг нь хөгжүүлж, баг бүрдүүлж, мэнторуудтай уулзуулан шилдэг гарааны бизнесийг шүүгчдийн тусламжтайгаар шалгаруулах арга хэмжээг зохион байгуулна.

Pitch Event

Хөтөлбөрийн танилцуулга семинар

Арга хэмжээ эхлэхээс өмнө, орон нутгийн байгууллагууд, чиглүүлэгчид, ажил ологчид, хөрөнгө оруулагч, оролцоогчид үйл ажиллагааг танилцуулах семинар зохион байгуулна.



Бизнес загварын хавтгай нь гарааны бизнесийг богино хугацаанд төлөвлөх, наг талбар дээр бүтэн дүр зургаар нь харах, бизнесийн стратегийг төлөвлөхөд нь туслалч чухал арга хэрэгсэл юм. 2 цаг

Бизнес загварын хавтгай (Business Model Canvas)

Бизнес эрхлэлтийн ач холбогдол


Төслийн багаас бүлгэмийн гишүүдэд болон залуу гарааны бизнес эрхлэгч нарт хэрхэн гарааны бизнесийн эко системийг сүм орон нутагтаа бүрдүүлэх талаар сургалт явуулна. Цаг

Оролцогчдод Стэнфордын их сургуулийн хөтөлбөр Загварчлах сэтгэлгээний сургалт явуулна. Цаг


Загварчлах сэтгэлгээний сургалт

1 дүгээр шат

2 дугаар шат



*1 Дөнгө, дүргэс 3 баг хурдасгуур хөтөлбөрт орно. Хурдасгуур хөтөлбөрийн туршид 1 баг шалгарч санхүүгийн дэмжлэг авна.





○ **Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд хэрэгжиж буй “Youth Startup Program” хөтөлбөр 3 үе шатаас бүрдэнэ.** ○

1 дүгээр шат

ОРОН НУТАГТ БИДНИЙГ ДЭМЖИХ БАГИЙГ БИЙ БОЛГОХ (Building Local Community)

Орон нутгийн гарааны бизнесийг дэмжих баг (Community) буюу энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн ба төрийн бус байгууллага, хувь хүмүүс, сайн дурынханыг нэгтгэж тухайн дүүрэг, аймаг, сумын гарааны бизнесийг дэмжих бүлгэм байгуулна.

Гарааны бизнесийн экосистемийг бүрдүүлэх




УР ЧАДВАР

Хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдлыг ханган, өөр өөр ур чадвар, мэдлэг, туршлага бүхий хүмүүсийг татах, төвлөрүүлэх, хамтын ажиллагаа, харилцаа холбоо, үүсгэх, хөгжүүлэх замаар урт хугацааны хүмүүн капитал бий болгох нь чухал.



НИЯТРАЛ

Олон бизнесийн төвлөрөл үүсгэх, бизнесийн зөвлөхүүдийн сүлжээг бий болгох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр уг салбарын талаарх ойлголт, мэдээллийг түгээх, эрдэмтэн судлаачдыг бизнес эрхлэгчидтэй холбох хэрэгтэй.




СОЁЛ

Гарааны бизнесийн өвөрмөц соёлыг бий болгох. Амжилттай энтрепренеруудын жишээг олон нийтэд түгээж уналт алдаа нь гарааны бизнес эрхлэгчидийн зайлшгүй туулах зам гэдгийг ойлгуулах, даван туулах арга зам байдгийг харуулах нь чухал.



ХӨРӨНГӨ

Засгийн газрын зүгээс Хөрөнгө оруулагчдыг уг салбарт оролцуулж баялгаа шилжүүлэх, эдийн засгийг идэвхжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх механизм, дэд бүтэц бүрдүүлэх шаардлагатай.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Хөрөнгө оруулалтыг татаж, өндөр эрсдэлтэй уг салбарт капиталын нөөцийг нэмэгдүүлэхийн тулд нээлттэй татварын оновчтой тогтолцоог бий болгож, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, тогтвортой байдлыг хангах нь чухал.




ХАРИЛЦАА ХОЛБОО

Өндөр хурдны интернетийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар олон улсын хэмжээнд гарааны бизнесүүдэд өсөн дэвжихэд шаардагдах дэд бүтэц, мэдлэг туршлага, боловсрол болон бусад сүлжээнд холбогдох боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

БҮРТГЭЛ (Registration)

ХЭН ОРОЛЦОХ БОЛОМЖТОЙ ВЭ?



Монгол Улсын иргэн, тухайн аймаг, дүүрэгт бүртгэлтэй оршин суугч байх,

15 – 34 насны иргэд байх,

Хувь хүн эсвэл багаараа оролцох боломжтой (заавал аж ахуйн нэгж байгуулсан байх шаардлагагүй),

Багийн гишүүдийн тоо 5 аас хэтрэхгүй байх,

Хөтөлбөр хэрэгжих хугацаанд зохиогдох арга хэмжээнд бүрэн хамрагдах боломжтой байх.

Болзол хангасан залуучууд өөрсдийн бизнес санаагаа 1 минутанд багтаан видео танилцуулга хэлбэрээр ирүүлнэ. Бүртгүүлсэн санаануудаас шалгарсан 50 оролцогч "Youth Startup Program" хөтөлбөрт хамрагдана.

1 минутын видео танилцуулгын агуулгын загвар



Хувь хүн, багийн танилцуулга

Хөтөлбөрт хамрагдах болсон шалтгаан

Бизнес санаа

ШАЛГАРУУЛАЛТЫН ГОЛ ШААРДЛАГА

Шийдэх гэж байгаа асуудлын талаар сайн ойлголт мэдлэгтэй байх;

Уламжлалт бус, шинэ, өмөрмөц санаа гаргасан байх;


Баг, гишүүдийн итгэл, үнэмшил, мэдлэг чадвар, хүсэл эрмэлзэлийг харуулах

СУРГАЛТ

БИЗНЕС ЭРХЛЭЛТ, ЭНТРЕПЕНЕРШИПИЙН АЧ ХОЛБОГДОЛ




Оролцогчдод энтрепенёршип болон гарааны бизнесийн талаар ерөнхий ойлголт өгөх, хувийн бизнес эхлүүлэх, эрхлэхийн ач холбогдол богино хугацаанд зөв эхлэл тавих, гарааны бизнесийн сорилт, бэрхшээлийн талаар мэдлэг олгох зорилготой.



ЗАГВАРЧЛАХ СЭТГЭЛГЭЭНИЙ СУРГАЛТ (Design Thinking)


Энэхүү сургалт нь АНУ-ын Стэнфордын их сургуулийн боловсруулсан хувь хүн, ажилтны бүтээлч сэтгэлгээ, ашигтай шийдэл олох чадварыг хөгжүүлэх зорилготой богино хугацааны хөтөлбөр юм. Үг системчилсэн арга техникийг технологийн компаний багууд ашиглан анх компьютерийн хулгана, "Iphone" зэрэг хувьсгалт өөрчлөлт авчирсан шийдлүүдийг бий болгосон байна.

Сургалтын загвар, үе шат



СУРГАЛТУУД

BMC (BUSINESS MODEL CANVAS)



Бизнес моделийн хавтан нь залуучуудад өөрийн гарааны бизнесийг богино хугацаанд төлөвлөх, нэг хавтан дээр бүтэн дүр зургаар нь харж, бизнесийн стратегийг төлөвлөхөд нь туслах хүчирхэг хэрэгсэл юм. Үүнийг хэрэглэж сургах сургалтыг практик байдлаар явуулна.

2 ТҮЛХҮҮР ҮЙЛ АЖИЛЛАГАА /KEY ACTIVITIES/

- Бизнесийн үнэ цэнийг өсгөх үйл ажиллагаа
- Түгээлтийн сүлжээ
- Хэрэглэгч, түншүүдтэй харилцах харилцаа
- Орлогыг бүрдүүлдэг үйл ажиллагаа

4 ҮНЭ ЦЭНИЙН НОТООЛГОО /VALUE PROPOSITIONS/

- Хэрэглэгч, түншүүдэд хүргэх үнэ цэнэ
- Хэрэглэгч, түншүүдийн асуудлыг шийдвэрлэх арга зам
- Ямар төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг, хэнд, ямар зорилгоор хүргэдэг вэ?
- Ямар төрлийн хэрэглээнд нийцэж байна вэ?

6 СУВАГ /CHANNELS/

- Ямар сувгаар дамжин өөрсдөд нь хүрээсэй гэж танай харилцагчид хүсдэг вэ?
- Яг одоо ямар сувгаар тэдэнд хүрч байгаа вэ?
- Чухам аль суваг нь үр өгөөж өндөртэй вэ?
- Сувгийн төрөл зүйлээ зөв тодорхойлох:
- Борлуулалтын дараах үйлчилгээ, хүргэлт, хэвлэл мэдээлэл гэх мэт

8 ОРЛОГО БҮРДҮҮЛЭГЧИД /REVENUE STREAMS/

- Бидний ямар зүйлд харилцагчид мөнгө төлөхөд бэлэн байдаг вэ?
- Одоогоор тэд юуны төлөө бидэнд мөнгө төлдөг вэ?
- Тэдний хэрхэн яаж төлөлт хийдэг нь орлого бүрдүүлэлтэд яаж нөлөөлдөг вэ?
- Төрлөө тодорхойлох: Борлуулалт, түрээс, хүүгийн орлого гэх мэт

1 ТҮЛХҮҮР ТҮНШҮҮД /KEY PARTNERS/

- Гол түншүүд хэн болох?
- Гол нийлүүлэгчид
- Гол түншүүдээс хүртэх нөөц боломжууд
- Гол түншүүдийн үйл ажиллагаа

3 ГОЛ НӨӨЦ /KEY RESOURCES/

- Танай бизнесийг үнэ цэнэтэй байлгаж чадах ямар төрлийн нөөц та бүхэнд байгаа вэ?
- Түгээлтийн сүлжээ, харилцагчтай харилцах харилцаа, орлогын бүтцийн чухам аль нь чухал вэ?
- Ямар төрлийн нөөцийг чухалчлах вэ? Биеийн хүчний, оюун ухааны, санхүүгийн, хууль эрхзүйн, зохиогчийн эрхийн чухам аль нь танайд чухал вэ?

5 ХАРИЛЦАГЧТАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА /CUSTOMER RELATIONSHIPS/

- Ямар төрлийн харилцааг үүсгээсэй гэж танай харилцагчид хүлээдэг вэ?
- Хүсэн хүлээдэг харилцаануудаас нь чухам алийг нь бодит харилцаа болгосон бэ?
- Ямар үнэ өртөгөөр энэ бүхнийг бүтээж болох вэ?
- Харилцааны аргуудаас чухам аль нь чухал болохыг сонгох:
- Хувийн зөвлөгөө, туслалцаа, Өөртөө үйлчлэх үйлчилгээ, Хамтарсан гэх мэт

7 ХАРИЛЦАГЧИЙН СЕГМЕНТ /CUSTOMER SEGMENTS/

- Чухам хэнд зориулан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ бид гаргадаг вэ?
- Хэн бидний хамгийн чухал харилцагч вэ?
- Олон нийт, онцгой хүрээ, онилсон цөөн хэдэн хүн үү?

9 ЗАРДЛЫН БҮТЭЦ /COST STRUCTURE/


- Танай компанийн зардал өндөр гаргах ёстой зүйл чинь чухам юу вэ?
- Ямар төрлийн нөөц бүрдүүлэхэд хамгийн өндөр төлбөр төлдөг вэ?
- Ямар төрлийн үйл ажиллагааг явуулахад хамгийн өндөр төлбөр төлдөг вэ?

2 дугаар шат

БИЗНЕС САНААНЫ ТАНИЛЦУУЛГА (Pitch Event)


"Pitch event" нь 54 цагийн турш үргэлжилдэг бөгөөд бүх оролцогчид 60 секундэд багтаан өөрийн бизнесийн санааг танилцуулж, эдгээрээс 10 санааг тодруулан оролцогчдыг баг болгон зохион байгуулж өрсөлдүүлдэг. Өрсөлдөөний явцад багууд "Стартап Монгол"-ын CEO менторуудын ганцаарчилсан зөвлөгөөг авч, бизнес төлөвлөгөө боловсруулна. Арга хэмжээний төгсгөлд 3 минутын танилцуулга бэлтгэн хөрөнгө оруулагчдад танилцуулснаар шилдэг бизнес төслүүд шалгарч, шаардлагатай хөрөнгө оруулалт олгосноор үйл ажиллагаа дуусдаг.

БАГ БҮРДҮҮЛЭЛТ (Team building)



Техникч

Компьютер инженерчлэл,
барьж байгуулах чадвар




Бизнес

График дизайн, үзүүлэн
сурталчилгаа, хэвлэл
мэдээлэл, энтертайнмент
хөгжүүлэлт



Уран бүтээлч

Бизнес хөгжил маркетинг,
борлуулалт үйлдвэрлэл,
стратег



Администратор

Төслийн удирдлага,
төлөвлөлт, зохион
байгуулалт, зохицуулалт,
санхүү


Багт хэрэгтэй үр чадвартай
Тодорхой, нэгдмэл сонирхолтой
Эрч хүч, урам зоригтой

ХҮМҮҮСИЙГ СОНГОХ

- Хамтран эзэмшихэд нээлттэй байж, удирдаж ажиллахад бэлэн бай


БАГ ГЭДЭГ БОЛ ХАМГИЙН ЧУХАЛ ЗҮЙЛ

САНААГАА БАТАЛГААЖУУЛАХ (Idea validation)



*БЭЭ- Бүтээгдэхүүний энгийн загвар (Minimum Viable product)

БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАГДАХ АРГА ХЭРЭГСЭЛҮҮД



ТӨСЛИЙН УДИРДЛАГА (Project management)



Санаагаа цаасан дээр буулгах, шинэ санаагаа хөгжүүлэх

Өөрт байгаа бүх санаануудаа аль болох эртхэн цаасан дээр буулгах



Эрэмбэлж тодорхой болго.

Зөвхөн гол чухал зүйлсийг ням гаригийн шалгаруулалтанд оруулах БЭЗ-г боловсруулах



Хуваарилалт хийж дуусгах хугацааг нь тодорхойл

Сайн удирдлага, менежментийг хэрэгжүүлэх

ШҮҮЛТ (Шалгаруулалт)

Асуудал/ Хэрэгцээ

- Зорилтот хэрэглэгчид нь хэн болох
- Зорилтот зах зээлийн хэмжээ
- Зах зээлийн судалгаа

Шийдэл/ Бүтээгдэхүүн

- Асуудлыг шийдэж чадсан эсэх
- Хэрэглэгчид яагаад худалдаж авна гэж?
- Загвар дизайны шийдэл

Хөрөнгө оруулалтын өгөөж

- Зардалын хэмжээ
- Бодит эсэх
- Борлуулах үнэ?

Орлого олох арга зам

- Хөрөнгө шаардлагатай эсэх
- Use of Proceeds?
- Хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа
- Хөрөнгө оруулалтын өгөөж
- Санал болгох хувьцааны тоо хэмжээ

Өрсөлдөх давуу тал

- Өрсөлдөгчид
- Өвөрмөц давуу тал
- Нийгмийн үр өгөөж
- Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Туршлага/ Түүх

- Бэлэн болсон загвар бүтээгдэхүүн байгаа эсэх
- Хөтөлбөрийн туршид хөгжсөн байдал
- Багийн чадвар

Давуу тал/ Сул тал

Танилцуулгын давуу ба сул тал

ХӨТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

Баасан гариг

- 17:30 Бүртгэл
- 19:00 Оройн хоол, танилцах
- 19:20 Нээлтийн ажиллагаа
- 20:30 Бизнес санаа танилцуулах
- 21:00 Санал хураах
- 21:15 Багт хуваагдах
- 22:00 Багуудад зааварчилгаа өгч, хэрэгцээт материалуудаар ханган ажилд нь оруулах

Бямба гариг

- 09:00 Цугларах, өглөөний цай
- 09:30 Багаар хуваагдан амралтын өдрүүдийн турш тусдаа сууж ажиллана
- 12:00 Өдрийн хоол
- 13:00 Зөвлөхүүдийн танилцуулга
- 14:00 Зөвлөхүүд багт туслах
- 14:30 Багуудын үйл ажиллагаа
- 18:30 Оройн хоол
- 19:30 Явцын тайлан, тусламж үзүүлэх
- 22:00 Ажлаа дуусгах

Ням гариг

- 09:00 Цугларах, өглөөний цай
- 10:00 Асуулт, хариулт
- 12:00 Өдрийн хоол
- 12:30 Зөвлөхүүд багт туслана
- 15:00 Багуудын үйл ажиллагаа
- 16:00 Оройн хоол
- 17:00 Төслийн танилцуулга
- 19:30 Шалгаруулалт
- 20:30 Шагнал гардуулалт
- 21:00 Хаалтын арга хэмжээ

3 дугаар шат

ХУРДАСГУУР ХӨТӨЛБӨР

/Бүртгэл 15 минут, Гэрийн даалгавар шалгах 30 минут, Зочин илтгэгч холбогдох сэдвийн дагуу лекц уншина 30 минут, Багууд Танилцуулгаа хийнэ 30 минут, Менторын цаг 1 цаг./

Хэрэглэгчийн сегмент сонгох

1,2 Дахь Долоо Хоног

Аливаа гарааны бизнесийн хувьд хэрэглэгчийн сегментээ зөв тодорхойлох нь амжилтын үндэс байдаг. Хэрэглэгчийн сегментийг тодорхойлох хэд хэдэн аргачлал байдагаас хамгийн түгээмэл ашиглагддаг нь TAM/SAM/SOM аргачлал юм.



- Нийт боломжит зах зээл
- Зорилгот зах зээл
- Борлуулах зах зээл

Бүтээгдэхүүний энгийн загвар

3 Дахь Долоо Хоног

Энэ нь энхийн бүтээгдэхүүн, анхдагч, хамгийн анхны хялбар загвар юм. MVP-г гаргах нь гарааны бизнесүүдийн хувьд маш их зардал, цаг хугацааг хэмнэдэгээрээ ач холбогдолтой.

Бүтээгдэхүүн, зах зээлийн нийцэл

4 Дэх Долоо Хоног

Хэрэглэгчийн сегментээ зөв тодорхойлж, бүтээгдэхүүнийхээ энгийн загварыг гаргасны дараа уг загварыг хэрэглэгчидэд ашиглуулж турших үе шат юм. Энэ нь тухайн стартапын санал болгож буй шийдэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хэрэглэгчийн сэтгэлд нийцэж буй эсэх, массаар үйлдвэрлэхэд хангалттай борлуулалгдах эсэхийг баталгаажуулах зорилготой. Хэрвээ уг нийцэл байхгүй бол БЭЗ-ээ дахин сайжруулах эсвэл Хэрэглэгчийн сегментээ солих хэрэгтэй.

Хөрөнгө босгох, бизнес найраа

5 Дахь Долоо Хоног

Гарааны бизнесийн амжилтанд хүрэх чухал хүчин зүйлсийн нэг нь Санхүүжилт босгох явдал юм. Энэ долоо хоногт үүсэн байгуулагчдад санхүүжилт хэрхэн босгох, хөрөнгө оруулагч нарт Pitch буюу бизнес найрааг хэрхэн хийхийг заана. Мөн гарааны бизнесийн санхүүжилтийг хэрхэн төлөвлөх, хэрхэн орлого зарлагаа зөв тооцох, зөв стратеги боловсруулах талаар мэдлэг олгоно.

DEMO DAY

"Pre-Accelerator" хөтөлбөрт амжилттай оролцсон гарааны бизнесүүдийг хөрөнгө оруулагчидтай уулзуулж дараагийн шатны санхүүжилт татах зорилгоор "Demo Day" арга хэмжээг зохион байгуулна.





Хөтөлбөрийн зорилтууд:

Дэлхий дахины бизнес эрхлэлтийн хөгжлийн чиг хандлага, туршлагаас хот, аймаг, сумдад нутагшуулан, орон нутгийн гарааны бизнесийг дэмжих загварыг туршин нэвтрүүлэх

Орон нутагт энтрепренершипийг хөгжүүлж залуучуудын оролцоог нэмэгдүүлэх

Энтрепренершипийг хөгжүүлэх чиглэлээр иргэд, байгууллагуудын санаачлага, хичээл зүтгэлийг нэгдмэл зорилгод чиглүүлэх, холбогдох байгууллагуудын харилцан ойлголцол, хамтын ажиллагааг хөгжүүлэх

Оюутан, залуучуудад гарааны бизнес эхлүүлэх, өргөжүүлэх сэдэл, урам зориг өгөх, гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ өргөжүүлэх мэдлэг олгох, холбоо харилцаагаа өргөжүүлэх боломж бүрдүүлэх

Орон нутагт гарааны бизнесээ эхэлж байгаа хүмүүст дэмжлэг үзүүлэх

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж гарааны бизнесээ эхэлж байгаа залуучуудыг чадавхижуулах

Орон нутгийн залуучуудаар удирдуулсан шинэлэг гарааны бизнесийг дэмжих, гарааны санхүүжилт олгох, бойжуулж, хөгжүүлэх

Facebook: Youth Startup Program Mongolia
Холбогдох дугаар: (976) 77116171
И-мэйл: info@yep-gfa.mn

МСҮТ-ИЙН ТӨГСӨГЧ, СУРАЛЦАГДЫН ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ СУРГАЛТ, ХӨТӨЛБӨР

ШИНЭ БИЗНЕС

МСҮТ-ийн төгсөгчдийн гарааны бизнес эрхлэх хандлагыг өөрчлөх, технологийн чадвар дээрээ тулгуурлан жижиг бизнесээ зөв төлөвлөх болон хэрэглэгчдийн хэрэгцээг мэдэрч, өрхийн үйлдвэрлэл, бизнесийг хөгжүүлэх арга замын кейс, чиглүүлэх сургалтууд энэхүү хөтөлбөрт багтдаг.

МСҮТ-ИЙН ТӨГСӨГЧ, СУРАЛЦАГЧДАД ГАРААНЫ БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ЯМАР АСУУДЛУУД ТУЛГАМДАЖ БАЙНА ВЭ?

- 1 Өөрсдийн чадвараа хэрхэн зөв үнэлэх вэ?
- 2 Чадвартаа тулгуурлан хийх ямар бизнесийн санаанууд орон нутгийн боломжийн хүрээнд байгааг хэрхэн тодорхойлох вэ?
- 3 Явал өөрийн гарааны бизнесээ амжилтанд хүргэх вэ?
- 4 Хэрэглэгчийн хэрэглээг хэрхэн сайн мэдэрч, бүтээгдэхүүнээ хөгжүүлж, борлуулалтаа хэрхэн өсгөх вэ?

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

ХӨТӨЛБӨРИЙН ОНЦЛОГ

- A** ОРОН НУТГИЙН БИЗНЕСИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА
ЗАМЫН КЕЙС ЧИГЛҮҮЛЭХ СУРГАЛТ
- B** БАГААР АЖИЛЛАХ АРГА /ГАРААНЫ БИЗНЕС, МЕНТОРООР
МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ БАГ, МЭРГЭЖЛИЙН ХӨТЛӨГЧ
УДИРДАН ЯВУУЛНА./
- C** БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭ /СУРАЛЦАГЧДЫН ХЭВШМЭЛ
СЭТГЭЛГЭЭГ ӨӨРЧИЛЖ, ӨСӨХ ХАНДЛАГЫГ ХӨГЖҮҮЛНЭ./
- D** УЯН ХАТАН БАЙДАЛ /МСҮТ-ИЙН ТӨГСӨГЧ, СУРАЛЦАГЧДЫН
МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛИЙГ ОРОН НУТГИЙН ДАВУУ ТАЛД
ТУЛГУУРЛАСАН БИЗНЕСИЙН ТӨРЛӨӨР ТӨРӨЛЖҮҮЛНЭ./

МСҮТ-ИЙН ТӨГСӨГЧДӨД ГАРААНЫ БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ 54 ЦАГИЙН СУРГАЛТЫН АГУУЛГА

Үе шат	Үндсэн хэсгүүд	Агуулга	
I	Гарааны бизнес хөгжих системийг бүрдүүлэх, хөгжүүлэх сургалт	Одоо МСҮТ-ИЙН суралцагчдад гарааны бизнес эрхлэхэд ямар асуудал тулгамдаад байна вэ?	Үйчилгээ /авто засвар, гоо сайхан/ Хүнсний үйлдвэрлэл Хөнгөн үйлдвэрлэл Мал аж ахуй Өрхийн үйлдвэрлэл Гар урлал
		Одоогийн энэ нөхцөл байдлыг гарааны бизнесийн хэмжээнд хэрхэн өөрчлөх вэ?	Үйлчилгээ, мал аж ахуй, Цагаан идээ, оёдол, нэхмэл гар урлалын чиглэлийн гарааны бизнесийн бодит кейс жишээ, шинэ санаанууд
		Гарааны бизнесийг амжилттай хөгжүүлэх шийдлийн аргуудыг хэрэглэх нь	Нэмүү өртөг шингээсэн ямар бүтээгдэхүүнээр аль зах зээлд төвлөрч гарах вэ?
		Орчин үеийн хэрэгцээнд нийцүүлэн бүтээгдэхүүнээ хөгжүүлэх аргууд	Бүтээгдэхүүний чанар, загвар, дизайн
II	Орон нутгийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, шинэчлэлт: Бүс нутаг-Улаанбаатар хот-Экспорт	Хэрэглэгчээ ойлгох	Бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцүүлэн үйлдвэрлэх
		Орон нутгийн үйлдвэрлэлийг Дайманд, үнэ цэнийн сүлжээний аргаар шинжлэх нь	Нэмүү өртөг шингээсэн ямар бүтээгдэхүүнээр аль зах зээлд төвлөрч гарах вэ?
		Гарааны бизнесийн төсөл боловсруулах	Төслийн агуулга
III	Хурдасгуур хөтөлбөр	Хөрөнгө босгох, бизнес найраа	Хөрөнгө босголтын хэлбэрүүд
		Хөрөнгө оруулагчдын сонирхлыг хэрхэн татах вэ?	Хөрөнгө оруулагчдыг ойлгох нь
		Хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулгыг хэрхэн бэлтгэх вэ?	

Сургалтын хөтөлбөрийн хуваарь

Оролцогчдод тавих шаардлага

- Цаашид хувиараа болон бүлгээрээ бизнес хийх сонирхолтой
- Бизнес төсөл, төлөвлөгөө боловсруулах туршлага, ур чадвартай бол сайн
- Тодорхой технологийн чадвар эзэмшсэн.

Хамрах хүрээ: 15-34 насны залуучуудыг оролцуулна.

/Хувь хүн болон багаараа оролцох боломжтой/


Оролцогчдыг сонгох шалгуур:

- Өөрсдийн бизнес санааны талаар товч танилцуулгыг явуулна./Хувь хүн болон багийн танилцуулга, мөн бизнес санааны товч танилцуулга байна./
- Баг болсон тохиолдолд 5-аас ихгүй гишүүнтэй

ЭХНИЙ ӨДӨР / ГАРААНЫ БИЗНЕСИЙН САНААГАА БАТАЛГЖУУЛАХ	
09:00 ~ 09:30	Хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаа
09:30 ~ 10:30	Орон нутгийн хөгжлийн боломж-гарц
10:30 ~ 11:15	Цагаан идээ, оёдол, нэхмэл, гар урлалын чиглэлийн гарааны бизнесийн бодит кейс жишээ, шинэ санаанууд
11:15 ~ 11:30	Цайны завсарлага
11:30 ~ 12:15	Оролцогчдын бизнеси санааны танилцуулга, тулгамдсан асуудал
12:15 ~ 13:00	Үйлчилгээ/ авто засвар, гоо сайхан/, хүнсний үйлдвэрлэл, өнгөн үйлдвэрлэл мал аж ахуй, үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, гар урлалын чиглэл тус бүрээр баг бүрдүүлэлт
13:00 ~ 14:00	Үдийн хоол
14:00 ~ 14:45	Одоогийн энэ нөхцөл байдлыг гарааны бизнесийн хэмжээнд хэрхэн яаж өөрчлөх вэ?
14:45 ~ 15:30	Өөрсдийн бизнес санаагаа шинжилж, оношлох / Багаар ажиллах дасгал
15:30 ~ 16:15	Өөрсдийн бизнес санаагаа шинжилж, оношлох / Багаар ажиллах дасгал
16:15 ~ 16:30	Цайны завсарлага
16:30 ~ 18:00	Менторын зөвлөгөө, сургалт
ХОЁРДАХЬ ӨДӨР. ОРЧИН ҮЕИЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХЭРЭГЛЭЭНД ТУЛГУУРЛАСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХӨГЖҮҮЛЭЛТ, ХӨРӨНГӨ БОСГОЛТ	
09:00 ~ 09:45	Өглөөний цай
09:45 ~ 11:15	Орон нутгийн үйлдвэрлэлийг Дайманд, үнэ цэнийн сүлжээний аргаар шинжлэх нь
11:15 ~ 11:30	Цайны завсарлага
11:30 ~ 13:00	Хөрөнгө босгох хэлбэрүүд
13:00 ~ 14:00	Үдийн хоол
ХОЁРДАХЬ ӨДРИЙН ҮДЭЭС ХОЙШ. /ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ШАЛГАРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ/	
14:00 ~ 14:45	Хөрөнгө оруулагчдын анхаарлыг хэрхэн татах вэ?
14:45 ~ 15:30	Хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулгыг хэрхэн бэлтгэх вэ?
15:30 ~ 16:15	Төслийн танилцуулга бэлтгэх
16:15 ~ 16:30	Багуудын танилцуулга: “Pitch Event”
16:30 ~ 18:00	Шалгаруулалт
18:00 ~ 18:30	Шилдэг бизнес санааг шалгаруулах ёслол

СУМЫН ТӨВИЙН ЗАЛУУЧУУДЫН ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

ОРОН НУТГИЙН БИЗНЕСИЙН ШИНЭ ХАНДЛАГА ӨРХИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧЭЭС ЭНТРЕПРЕНЕР РҮҮ ШИЛЖИХ



ХӨТӨЛБӨРИЙН ОНЦЛОГ

- A** БАГААР АЖИЛЛАХ /ГАРААНЫ БИЗНЕС, МЕНТОРООР МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ БАГ, МЭРГЭЖЛИЙН ХӨТЛӨГ УДИРДАН ЯВУУЛНА/
- B** БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭ /СУРАЛЦАГЧДЫН ХЭВШМЭЛ СЭТГЭЛГЭЭГ ӨӨРЧИЛЖ, ӨСӨХ ХАНДЛАГЫГ ХӨГЖҮҮЛНЭ/
- C** УЯН ХАТАН БАЙДАЛ/ОРОН НУТГИЙН ДАВУУ ТАЛД ТУЛГУУРЛАСАН БИЗНЕСИЙН ТӨРЛӨӨР ТӨРӨЛЖҮҮЛНЭ/
- D** ОРОН НУТГИЙН БИЗНЕСИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗАМЫН КЕЙС, ЧИГЛҮҮЛЭХ СУРГАЛТ

СУМЫН ТӨВИЙН ЗАЛУУЧУУДЫН ГАРААНЫ БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ 54-Н ЦАГИЙН СУРГАЛТЫН АГУУЛГА

Үе шат	Үндсэн хэсгүүд	Агуулга	
I	Орон нутагт гарааны бизнесийг хөгжүүлэх суурь нөхцлийг бүрдүүлэх /Үйлчилгээ авто засвар, гоо сайхан/ Хүнсний үйлдвэрлэл Хөнгөн үйлдвэрлэл Мал аж ахуй Өрхийн үйлдвэрлэл Гар урлал	Гарааны бизнес ямар асуудал тулгамдаад байна вэ?	
		Одоогийн энэ нөхцөл байдлыг гарааны бизнесийн хэмжээнд хэрхэн өөрчлөх вэ?	Үйлчилгээ, мал аж ахуй, Цагаан идээ, оёдол, нэхмэл гар урлалын чиглэлийн гарааны бизнесийн бодит кейс жишээ, шинэ санаанууд
		Гарааны бизнесийг амжилттай хөгжүүлэх ший Нэмүү өртөг шингээсэн ямар бүтээгдэхүүнээр аль зах зээлд төвлөрч гарах вэ? длийн аргуудыг хэрэглэх нь	
		Гарааны бизнесийг амжилттай хөгжүүлэх шийдлийн аргуудыг хэрэглэх нь	
II	Орчин үеийн хэрэгцээнд нийцүүлэн бүтээгдэхүүнээ хөгжүүлэх аргууд, Бүтээгдэхүүний чанар, загвар, дизайн	Хэрэглэгчээ нарийн мэдэрч ойлгох	Бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцүүлэн үйлдвэрлэх
		Орон нутгийн үйлдвэрлэлийг Дайманд, үнэ цэнийн сүлжээний аргаар шинжлэх нь	Нэмүү өртөг шингээсэн ямар бүтээгдэхүүнээр аль зах зээлд төвлөрч гарах вэ?
		Хөрөнгө оруулагчдад зориулж бизнесийн төсөл боловсруулах	Төслийн агуулга
III	Хурдасгуур хөтөлбөр	Хөрөнгө босгох, бизнес найраа	
		Хөрөнгө оруулагчдын сонирхлыг хэрхэн татах вэ?	Хөрөнгө оруулагчдыг ойлгох нь
		Хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулгыг хэрхэн бэлтгэх вэ?	
МЕНТОРЫН ЗӨВЛӨГӨӨ, ХАМТЫН АЖИЛЛАГАА			

Сургалтын хөтөлбөрийн хуваарь

Оролцогчдод тавих шаардлага

- Цаашид хувиараа болон бүлгээрээ бизнес хийх сонирхолтой
- Бизнес төсөл, төлөвлөгөө боловсруулах туршлага, ур чадвартай бол сайн
- Тодорхой технологийн чадвар эзэмшсэн.

Хамрах хүрээ: 15-34 насны залуучуудыг оролцуулна.

/Хувь хүн болон багаараа оролцох боломжтой/

Оролцогчдыг сонгох шалгуур:

- Өөрсдийн бизнес санааны талаар товч танилцуулгыг явуулна./Хувь хүн болон багийн танилцуулга, мөн бизнес санааны товч танилцуулга байна./
- Баг болсон тохиолдолд 5-аас ихгүй гишүүнтэй

ЭХНИЙ ӨДӨР / ГАРААНЫ БИЗНЕСИЙН САНААГАА БАТАЛГЖУУЛАХ	
09:00 ~ 09:30	Хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаа
09:30 ~ 10:30	Орон нутгийн хөгжлийн боломж-гарц
10:30 ~ 11:15	Цагаан идээ, оёдол, нэхмэл, гар урлалын чиглэлийн гарааны бизнесийн бодит кейс жишээ, шинэ санаанууд
11:15 ~ 11:30	Цайны завсарлага
11:30 ~ 12:15	Оролцогчдын бизнеси санааны танилцуулга, тулгамдсан асуудал
12:15 ~ 13:00	Үйлчилгээ/ авто засвар, гоо сайхан/, хүнсний үйлдвэрлэл, өнгөн үйлдвэрлэл мал аж ахуй, үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, гар урлалын чиглэл тус бүрээр баг бүрдүүлэлт
13:00 ~ 14:00	Үдийн хоол
14:00 ~ 14:45	Одоогийн энэ нөхцөл байдлыг гарааны бизнесийн хэмжээнд хэрхэн яаж өөрчлөх вэ?
14:45 ~ 15:30	Өөрсдийн бизнес санаагаа шинжилж, оношлох / Багаар ажиллах дасгал
15:30 ~ 16:15	Өөрсдийн бизнес санаагаа шинжилж, оношлох / Багаар ажиллах дасгал
16:15 ~ 16:30	Цайны завсарлага
16:30 ~ 18:00	Менторын зөвлөгөө, сургалт
ХОЁРДАХЬ ӨДӨР. ОРЧИН ҮЕИЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХЭРЭГЛЭЭНД ТУЛГУУРЛАСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХӨГЖҮҮЛЭЛТ, ХӨРӨНГӨ БОСГОЛТ	
09:00 ~ 09:45	Өглөөний цай
09:45 ~ 11:15	Орон нутгийн үйлдвэрлэлийг Дайманд, үнэ цэнийн сүлжээний аргаар шинжлэх нь
11:15 ~ 11:30	Цайны завсарлага
11:30 ~ 13:00	Хөрөнгө босгох хэлбэрүүд
13:00 ~ 14:00	Үдийн хоол
ХОЁРДАХЬ ӨДРИЙН ҮДЭЭС ХОЙШ. /ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ШАЛГАРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ/	
14:00 ~ 14:45	Хөрөнгө оруулагчдын анхаарлыг хэрхэн татах вэ?
14:45 ~ 15:30	Хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулгыг хэрхэн бэлтгэх вэ?
15:30 ~ 16:15	Төслийн танилцуулга бэлтгэх
16:15 ~ 16:30	Багуудын танилцуулга: “Pitch Event”
16:30 ~ 18:00	Шалгаруулалт
18:00 ~ 18:30	Шилдэг бизнес санааг шалгаруулах ёслол

ГАРААНЫ БИЗНЕС, ЭНТРЕПРЕНЁРШИП/БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР ТОЛИОС

Агуулга

I. Гарааны бизнес

II. Энтрепренершип-бизнес эрхлэлт

I. ГАРААНЫ БИЗНЕС(START-UP BUSINESS)

1. Гарааны бизнес/Старт-ап бизнес(Start-up Business) - Шинэ бизнес, шинэ бизнес эрхлэх. “Start-up”- англиар шууд утгаараа “процесс, үйл ажиллагааны эхлэл”, “гараанаас эхлэх” гэсэн үг бөгөөд “Start-up business” нь шинэ бизнес эрхлэх гэсэн утгыг агуулдаг. Энэ нэр томъёог анх 1976 онд Форбес (Forbes) сэтгүүлд шинээр байгуулагдан, богино хугацаанд бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа компанийг нэрлэхдээ хэрэглэсэн ба 1990-ээд оноос түгээмэл болсон нь мэдээллийн технологийн салбар эрчимтэй хөгжиж, олон тооны компани шинээр байгуулагдсантай холбоотой гэж үздэг. Мэргэжилтнүүдийн үзсэнчлэн шинээр эхэлж буй бизнес бүрийг старт-апд хамруулах нь оновчгүй. Гарааны бизнесийн гол онцлог нь ямар нэг шинэ санаа, шинэ бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээ санал болгох явдал. Дэлгүүр нээх, үсчин, гоо сайхан ажиллуулж эхлэх зэргийг энд хамруулахад төвөгтэй, “Facebook”, “Intel” болон “Google” зэрэг томоохон компаниуд гарааны бизнесээс эхэлж байсан ба түүний сонгодог төлөөлөл юм.

2. Гарааны бизнесийн үндсэн шинжүүд(Main characteristics of Start-up Business):

- Старт-ап бизнес нь дөнгөж эхэлж буй шинэ бизнес. Гарааны зарим бизнес амжилттай хөгждөг бол нөгөө хэсэг нь оршин тогтнож чадалгүй, үйл ажиллагаагаа зогсоодог.
- Старт-ап бизнес бол юуны өмнө шинэ санаан дээр тулгуурладаг. Старт-ап бизнес эрхлэгчид нь гол төлөв тухайн салбартаа ямар нэг шинэ санааг бизнес болгон хөгжүүлдэг.
- Старт-ап бизнесийн бүхий л үйл ажиллагаа эхлэлийн шатандаа оршиж байдаг.
- Хөрөнгө оруулагч хайх, түүнийг олох эсэхээс гарааны бизнесийн цаашдын амжилт ихээхэн хамааралтай.
- Түргэн хугацаанд шинэ санаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлдэг. Энэ нь гарааны бизнесийн амжилтын нэг гол нөхцөл юм. Хөрөнгө оруулагчид гарааны бизнесийн тодорхой төслөөс богино хугацаанд ашиг хүртэхийг эрмэлздэг. Нөгөө талаар, бизнес нь удаан хугацаагаар гарааны бизнес байх боломжгүй.

3. Гарааны бизнесийн амжилтын гол хүчин зүйлс (Key success factors of Start-up business):
 - Үүсгэн байгуулагчдын шинэ санаа, түүнийг бизнес болгон хөгжүүлэх чин эрмэлзлэл, хүсэл тэмүүлэл, мэдлэг;
 - Гарааны бизнесийг эрхлэх бэлтгэл сайтар хангасан байдал, үндэслэлтэй бизнес төсөл боловсруулалт;
 - Старт-ап бизнес эрхлэх баг, хамт олны хөдөлмөр зүтгэл, нэгдэл нягтрал;
 - Гарааны бизнесийн төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх чадвартай, харилцан бие биенээ нөхөх түншүүд;
 - Гарааны бизнесийн санаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэлэг байдал (инноваци), ялгагдах онцлог, оновчтой сурталчилгаа, таниулга;
 - Хөрөнгө оруулагч, хангалттай хэмжээний санхүүжилт олсон байдал;
4. Гарааны бизнесийн хөгжлийн үе шат (Development stages of Start-up business) -
 - Эхлэлийн үе шат (Seed stage)- Бизнесийн шинэ санааг хөгжүүлэх, зах зээлийн судалгаа хийх, техник–эдийн засгийн үндэслэл боловсруулах, бүтээгдэхүүний загвар, үйлчилгээний концепци гаргах, бизнес төлөвлөгөө бэлтгэх, хөрөнгө санхүүжилтын эх үүсвэр олох гэх зэрэг үйл ажиллагаа явагддаг.
 - Эхэн үе шат (Early stage)- Бизнесийн шинэ санааг туршин хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд эхлэн гаргаж бизнесийн үйл ажиллагааг эхлэн явуулах үе шат.
 - Дунд шат (Midstage)- Бизнес тогтвортой болж, компаний үйл ажиллагаа жигдрэн, бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэж, зах зээлд эзлэх байр суурь бэхжинэ.
 - Сүүлийн шат(Last stage)- Компаний үйл ажиллагаа бүрэн тогтворжиж, старт-апын шатнаас гарна. Цаашид хөрөнгийн зах зээлд нээлттэй хувьцаа гаргах боломжтой.
5. Бизнес санаа (Business idea) – Санхүүгийн хувьд ашиг, орлого олж болох бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ бий болгох ямар нэг санаа.
6. Бизнес санал (Business offer) – Санхүүгийн хувьд ашиг, орлого олох боломжтой бизнесийн санал.
7. Бизнесийн санаа/ санал/төслийн танилцуулга хийх(Business idea/offer/project presentation)- Хэрэгжүүлэхээр зэхэж буй бизнесийн санаа/санал/ төслөө түнш, хөрөнгө оруулагчдад танилцуулах үйл ажиллагаа.
8. Бизнес санаа/саналыг нягтлан баталгаажуулах(Proof of concept)- Ямар нэг бизнес санаа/ саналыг хэрэгжих боломжтой гэдгийг нотлох ажиллагаа. Венч хөрөнгө оруулагчдын зүгээс гол төлөв тухайн бизнес санаа хир баталгаатай, хөгжих боломжтой гэдгийн нотолгоог шаарддаг байна.
9. Бизнес загвар (Business model)- Тухайн бизнесийг эрхлэх арга зам, үйл ажиллагааны төлөвлөсөн төсөөлөл бөгөөд бизнес эрхлэхэд шаардагдах нөөц, хөрөнгө тэдгээрийн бүрдүүлэлт, захиалга, нийлүүлэлт, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүүжилт, маркетинг, борлуулалт, хүний нөөц бүрдүүлэлт, удирдлага, зохион байгуулалт зэрэг бүхий л асуудлын шийдлийг агуулдаг.

10. Бизнес загварын хавтгай(Business Model Canvas)- Бизнес эрхлэх үйл ажиллагааг нарийвчлан загварчилж харуулахад ашигладаг хүснэгт.
11. Бизнесийн цар хүрээ, хэмжээ(Scale)- Тухайн бизнесийн масштаб, хамрах хүрээ, салбар, үйлдвэрлэлийн хэмжээг илэрхийлсэн ойлголт.
12. B2B (Business to Business)- Байгууллагын бизнесийн үйл ажиллагаанд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх бизнесийн хэлбэр. Гол хэрэглэгч, худалдан авагч нь ямар нэг байгууллага, компани байдаг.
13. B2C (Business to Consumer)- Хэрэглэгч, худалдан авагчдын эцсийн хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх бизнес. Хүн ам гол эцсийн хэрэглэгч болдог.
14. Гарааны бизнесийн “үхлийн хөндий”(“Death Valley” of Start-up business)- Аливаа бизнесийн хөгжлийн эхлэлийн болон эхэн үе шатуудад тулгардаг хамгийн хүнд, эмзэг үе. Эдгээр шатанд зах зээлийг судлах, техник-эдийн засгийн тооцоо судалгаа хийх, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эхлүүлэх, маркетингийн үйл ажиллагаа зэрэгт хөрөнгө санхүүжилт хэрэгтэйн дээр орлого, ашиг хараахан олж эхлээгүй байдаг. Энэхүү хүнд үеийг олон бизнес давж гарч чаддаггүйгээс бизнесийн “үхлийн хөндий” гэж нэрлэжээ. Энэ үе шатыг амжилттай даван туулахад бизнесийн таатай орчин-экосистем бүрдүүлэх, бизнесийг дэмжих үйл ажиллагаа явуулдаг байгууллага, бүтцүүд: инкубатор, акселератор, парк болон бизнес зөвлөхүүд чухал үүрэгтэй.
15. Гарааны бизнесийн хөрөнгө оруулалтын гол эх үүсвэр(Main investment sources of Start-up business):
 - Эхлэлийн буюу “гарааны” хөрөнгө оруулалт(Seed investment)- “Seed” – үр хөврөл, суулгац гэсэн үг. Бизнесийн хамгийн эхлэлийн шатанд хийгдэх хөрөнгө оруулалт, гол төлөв “3F- Founder, Family, Friends” буюу “бизнес эрхлэгч/үүсгэн байгуулагч-өөрөө”, “гэр бүл/төрөл садан”, “найз нөхөд” нь эхлэлийн хөрөнгө оруулагч байж болдог. Түүнчлэн бусдаас- хувь хүн, компаниас хөрөнгө оруулалт татаж болно.
 - “Анжел” хөрөнгө оруулалт(Angel investment)- Старт-ап бизнесийн эхлэлийн шатанд “3F”-ээс бусад эх үүсвэрээс татсан хөрөнгө оруулалт. “Angel”- “тэнгэрийн элч, авралын элч, сахиусан тэнгэр” гэсэн үгнээс гаралтай ба чухамхүү гарааны бизнесийн эхлэлийн хамгийн эмзэг үе- “Үхлийн хөндий” –г давахад старт-ап бизнесийн аврал болдог тул ингэж нэрлэжээ. “Анжел” хөрөнгө оруулагчид(Angel investors)- гол төлөв бага хэмжээний хөрөнгийн дэмжлэг үзүүлэх ба голчлон хувь хүмүүс байдаг.
 - Вэнч хөрөнгө оруулалт (Venture investment)- Ирээдүйтэй старт-ап бизнест хийх хөрөнгө оруулалт, гол төлөв ихээхэн эрсдэлтэй, аз туршсан шинжтэй байх боловч өндөр өгөөжтэй байдаг. Эх үүсвэрүүд нь тэтгэврийн сан, даатгалын сан, компаний хөрөнгө, иргэдийн хуримтлал, хөрөнгө оруулагчдын болон улсын төсөв, хөрөнгө байх боломжтой.
 - “Завсарын” хөрөнгө оруулалт (Mezzanine financing)-“Мезонин”- холбоос,

- тулаас, хоёр байшинг холбосон хоолой гэсэн үг. Бизнес амжилттай хөгжиж, компани гарааны үеэсээ дараагийн шатанд шилжих үед хийгддэг хөрөнгө оруулалт.
16. Хөрөнгө оруулалт хайх ажиллагаа (Seeking for investment) – Бизнес санаа/ төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг гаргаж чадах санхүүжүүлэгч хувь хүн, байгууллага, сан зэргийг олоход чиглэсэн үйл ажиллагаа.
17. Гарааны бизнест хөрөнгө оруулалт татах, санхүүжилт олж авахад нөлөөлөх амжилтын гол хүчин зүйлс (Key success factors to improve chances of getting money from investors):
- Зөвхөн санаа биш, тодорхой бизнес санал болгох (Present a Business, Not an Idea)- Хөрөнгө оруулагчид бараг өдөр бүр бизнесийн олон санааг сонсдог ба зарим нь сайхан санаа байдаг ч биелэх эсэх эргэлзээтэй. Иймд хэрэгжих боломжтой бизнес гэдгийг харуулж чадах нотолгоо болох зүйлсийг сайтар бэлтгэх нь чухал. Яг ямар бүтээгдэхүүн, үйлчилгээ болон бизнес загвар бий болгох, хэн ажиллах, бизнес эрхэлж байсан туршлагатай эсэх, эсвэл тийм хүнтэй хамтран ажилладаг, зөвлөгөө авдаг г.м.
 - Бизнесийн орлогын мөнгөн урсгалыг харуулах (Show Cash Flow)- Бизнесийн мөнгөн урсгалын төлөвлөлтийн аль болох бодитойгоор гаргаж, оруулсан хөрөнгийг нь эргүүлж төлж чадах хангалттай хэмжээний орлого олох боломжтой гэдгээ нотлон харуулах, өөрөөр хэлбэл, хэдий хэмжээний орлого, ашгийг юунаас, яаж олохоо харуулна гэсэн үг.
 - Өөртөө юу хэрэгтэйгээ, юу олж авахыг хүсч байгаагаа сайтар тодорхойлох (Know What You Need & Want)- Хэдий хэмжээний хөрөнгө оруулалт, чухам юунд шаардлагатай, хөрөнгө оруулагчийн оролцоо ямар байхыг маш тодорхой болгох нь чухал.
 - Өөрөө биечлэн судлах (Do Your Research)- Бизнестээ чухам юу хэрэгтэй байгаагаа сайн тодорхойлж чадсан бол хөрөнгө оруулагчдыг хайх судалгааг хийж эхлэх, Хөрөнгө оруулагчдын чуулган г.м., тэдгээрийг олж болох бүхий л арга хэмжээнд оролцох, харилцаа холбоо тогтоохыг оролдох хэрэгтэй.
 - Бизнесийн стратеги ба алсын зорилгоо тодорхойлох (Develop Strategy & Vision)- Өөрийн бизнесийн ирээдүйн талаарх төсөөллөө сайтар бодож боловсруулан, алс хэтийн зорилго, стратегиа тодорхойлж, бизнесээ цаашид хэрхэн хөгжүүлэх, өсгөх, тэлэх, ингэхдээ хэнтэй хамтран, бизнесээс хэрхэн гарах г.м. асуултуудад тодорхой хариулттай байж энэ талаар хөрөнгө оруулагчдад танилцуулах нь чухал.
18. Дахин старт-ап бизнес эхлүүлэх (Re-start-up)- Бизнес эрхлэгч урьдын алдаанаас суралцсан туршлагадаа тулгуурлан старт-ап бизнесийг дахин эхлүүлэх хэлбэр. Амжилт олох магадлал илүү өндөр байдаг.
19. Дараагийн старт-ап(Second start-up)- Бизнес эрхлэгч хоёр дахь старт-ап бизнесээ эхлүүлэх үйл ажиллагаа. Гол төлөв эхний старт-ап бизнесээ амжилттай хөгжүүлж, тогтворжуулсны дараа эхэлдэг.

20. Хэмнэлттэй старт-ап(Lean start-up)- Бизнес санааг хамгийн хэмнэлттэй хэлбэрээр туршин хөгжүүлэх арга, технологи бөгөөд бизнесийг аль болох бага зардлаар эхлүүлж, туршсаны үндсэн дээр цаашид хөгжүүлэхэд чиглэгддэг. Анх Эрик Риз(Eric Ries) дэвшүүлжээ.
21. “Бүсээ чангалах” (Bootstrapping)- Өөрийн хөрөнгө оруулалт: Бизнес эрхлэхдээ бусдаас хөрөнгө оруулалт, зээл авахгүйгээр өөрийн хөрөнгөөр эхлүүлэх хэлбэр.
22. Бизнес “найраа”(Pitch)- Маш богино хугацаанд бизнес саналаа хөрөнгө оруулагчид танилцуулж, тэдгээрийн сонирхолыг татах ажиллагаа. “Elevator Pitch” буюу “Цахилгаан шатны найраа” - потенциал хөрөнгө оруулагчийг цахилгаан шатанд явж байхад нь бизнес эрхлэгчид саналаа түргэн хугацаа(2 мин хүртэл)-нд танилцуулах оролдлогоос үүдэлтэй ойлголт.
23. Нягтлан шалгах судалгаа (Due Diligence) — Вэнч сан болон хөрөнгө оруулагчийн зүгээс санхүүжилт/хөрөнгө оруулалт хийхийн тулд компаний үйл ажиллагааг бүхий л талаас нь сайтар судлах, шалгах ажиллагаа.
24. Харилцан тохиролцооны протокол(Term sheet) – Хөрөнгө оруулалтын гол нөхцөлүүд, арга хэлбэрийн талаар харилцан тохиролцсон протокол/ хууль эрх зүйн хувьд хүчин төгөлдөр биш байдаг.
25. Капитал (Capital)- Ашиг орох зорилгоор оруулсан хөрөнгө (гол төлөв мөнгөн хөрөнгө). Бизнес эрхлэгч нь хөрөнгөө өсгөснөөр бизнесээ өргөжүүлэх/хөгжүүлэх боломжтой болдог.
26. Вэнч капитал (Venture capital)- Ирээдүйтэй, шинэ бизнес, старт-ап компанид хөрөнгө оруулалт хийхэд ашиглагдах хувийн хөрөнгө. Шинжлэх ухааны шинэ ололт, өндөр технологи, инновацийг нэвтрүүлэх хүрээнд голчлон хийгдэх ба хөрөнгө оруулсан төслүүдийн 70-80 хувь нь өгөөжгүй байх боловч үлдсэн 20-30 хувь нь өндөр өгөөж өгч бүх алдагдлыг нөхдөг байна.
27. Вэнч компани (Venture компани) – Инновацийн үйлдвэрлэл, гарааны бизнесийн төслийг голчлон санхүүжүүлдэг хөрөнгө оруулалтын компани.
28. Вэнч капиталист (Venture capitalist)- Вэнч капиталын сан, компаниудтай хамтран ажиллаж, старт-ап бизнест эрсдэл өндөртэй, аз туршсан хөрөнгө оруулалт хийдэг хувь хүмүүс. Эдгээр хөрөнгө оруулагчид нь гол төлөв өөрсдийн сайн мэддэг салбартаа хөрөнгө оруулалт хийхийг эрмэлздэг.
29. Вэнч сан(Venture fund)- Эрсдэл өндөртэй, аз туршсан бизнесийг санхүүжүүлэх замаар хөрөнгө мөнгийг өсгөж, ашиг олох зорилгоор мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг сан.
30. Вэнч бизнес (Venture Business) – Ирээдүйтэй, түргэн өсөлттэй, гол төлөв инноваци, технологийн бизнест хөрөнгө оруулалт хийх замаар ашиг олоход чиглэсэн бизнес. Эрсдэл өндөр боловч хөрөнгө оруулалтын өгөөжийн хэлбэрээр ихээхэн хэмжээний ашиг олох боломжтой. Энэ нь дэлхий дахинд бизнесийн томоохон салбар болон хөгжиж байгаа бөгөөд хувь хүмүүс, урлаг спортын одод хөрөнгөө энэ бизнест оруулах хандлага түгээмэл байна. Жишээлбэл, зодог тайлаад байгаа нэрт сагсан бөмбөгчин Коб Брайнт (Kobe Bryant) технологийн бизнес эрхлэгч,

хөрөнгө оруулагч Жэф Стибэл (Jeff Stibel)-тэй хамтран 100 сая ам.долларын вэнч сан байгуулсан ба технологи, медиа болон өгөгдлийн компаниудад хөрөнгө оруулалт хийхээр болсон байна. Тэд 2013 оноос эхлэн спортын медиа веб сайт болох “The Players Tribune”, телемаркетингийн програм хангамжийн компани “RingDNA”, видео тоглоомын дизайны фирм “Scopely” зэрэг 15 бизнест амжилттай хөрөнгө оруулалт хийгээд байгаа ажээ.

31. Вэнч зөвлөх(Gatekeeper)- “Хаалгач” гэсэн утгатай. Вэнч санд хөрөнгө оруулахыг зорьсон хөрөнгө оруулагчдын санхүүгийн зөвлөх.
32. Олон нийтээс хөрөнгө хуримтлуулах ажиллагаа(Crowdfunding) – “crowd” – «олон нийт», funding – «сан бүрдүүлэлт» гэсэн үгнээс гаралтай. Ямар нэг байгууллага, хүмүүсийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор сайн дурын үндсэн дээр нийтээр нэгдэж хөрөнгө мөнгө хуримтлуулах үй ажиллагаа. Сүүлийн жилүүдэд старт-ап бизнесийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэх нэг хэлбэр болон хөгжиж байна.
33. Олон нийтийн хуримтлалын сан (Crowdfund) – Нийтээр нэгдэж хуримтлуулсан мөнгө хөрөнгө.
34. Сан бүрдүүлэлт (Fundraising) – Мөнгө хөрөнгө хайх, татан төвлөрүүлэх, “хөрөнгө босгох” үйл ажиллагаа.
35. Сангуудын сан(Fund of funds)- Тодорхой нэг сангаас бусад сангуудад хөрөнгө оруулалт хийх хэлбэр.
36. Хөрөнгө оруулалтын жилийн өгөөж(Return of Investment/ROI) – Хөрөнгө оруулалтаас жилд олсон ашгийн хэмжээгээр тодорхойлогдох, бизнест оруулсан хөрөнгийн эргэн төлөгдөх өгөөжийн хувь хэмжээ. Жишээ нь: Хөрөнгө оруулагч старт-ап бизнест 20.0 сая төг.-ийн хөрөнгө оруулалт хийж, нийт хөрөнгийн 20 хувийг эзэмшдэг ба уг компаний үнэлгээ 400 сая төг. болсон гэвэл хөрөнгө оруулалтын өгөөж 80 сая төг. болно.
37. Хөрөнгө оруулагчийн эрх(The right of the investor) – Хөрөнгө оруулсны дараа хөрөнгө оруулагчид олгох эрх (бизнесийн хувь, ашгийн хувь, борлуулалтын хувь, бүтээгдэхүүний хувь г.м.).
38. Хөрөнгө оруулагчийн хувь(The share of the investor) – Хөрөнгө оруулагчид ногдох ашгийн хувь.
39. Барьцаа/баталгаа (Collateral) – Бизнес амжилтгүй болсон нөхцөлд хөрөнгө оруулагчийн хохирлыг барагдуулах хөрөнгө/ мөнгө.
40. Хөрөнгө оруулалтын төсөл(Investment project) – Ажил хэрэг болгон хэрэгжүүлэхийн тулд хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа бизнес төсөл.
41. Төсөл санаачлагч(Project Initiator) –Бизнес санааг бодож олон түүнийг хэрэгжүүлэх төслийг үндэслэгч.
42. Төслийн нийт өртөг (Total project budget) – Төслийг санаачлагч, бусад оролцогчдын зүгээс болон хөрөнгө оруулагчдын зарцуулсан ба оруулсан нийт мөнгөн хөрөнгийн хэмжээ.
43. Төсөл хайх ажиллагаа (Seeking for project) – Илүү ашигтай бизнес санаа/ төсөл олоход чиглэсэн үйл ажиллагаа.

44. Эрсдэл(Risk/Project risk/Investment risk) – Тодорхойгүй нөхцөл байдлын улмаас төслийн үр ашгийн үзүүлэлтүүд буурах магадлал. Бизнес төслөөс олох орлого өндөр байх тутам, эрсдэл төдийчинээ өндөр байна. Төслийн эрсдлийн түвшин: орлого- 10% хүртэл- бага; 20% хүртэл- дунд зэрэг; 35% хүртэл – дундаас дээгүүр; 35% -аас дээш- өндөр байна.
45. Хувьцаа (Stock) –Үнэт цаасны хэлбэрээр байгаа компаний хөрөнгө.
46. Давуу эрхийн хувьцаа(Preferred Stock)- Компаний хувьцааны нэг хэлбэр бөгөөд энгийн хувьцаанаас ялгах онцлог нь давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг эхний ээлжинд хуваарилагдах боловч, хувьцаа эзэмшигчдийн хурал дээр санал өгөх эрхээр хангагдахгүй.
47. Шилжих өр (convertible debt)- Бизнест оруулсан хөрөнгө оруулалтаа хожим нь компаний хувь эзэмшил болгон эргүүлж олох хэлбэр.
48. Өмч (Equity)- Компани, байгууллагын өмч
49. Хөрөнгө оруулалтын зориулалт (Purpose of the investment) – Хөрөнгө оруулалтыг ашиглах зориулалт, зарцуулалтын хэлбэр, ангилал.
50. Хөрөнгө оруулалтын хугацаа (Investment period) – Бизнест хөрөнгө оруулсан хугацаа.
51. Хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хугацаа(Payback period of invetsment)- Хөрөнгө оруулагч ямар нэг бизнест оруулсан хөрөнгөө эргүүлэн олж авах хугацаа.
52. Хөрөнгө оруулалтын төрөл (Types of invetsment) – Бизнест шаардлагатай хөрөнгийг оруулах хэлбэр:
 - Зээл (Lending)
 - Хувь эзэмшил (Ownership)
 - Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө (Cash equivalents)
53. Хувийн хөрөнгө оруулагч (Individual investor) – Бизнес санаа/төслийг санаачлагчтай танилын холбоотой хөрөнгө оруулагч хувь хүн.
54. Тэргүүлэх хөрөнгө оруулагч (Lead investor)- Тодорхой бизнесийн хөрөнгө оруулалтын ихэнхи хувийг гаргасан венч капиталын компани, эсвэл хувийн хөрөнгө оруулагч
55. Эхлэн сонголт хийх (First refusal) – Санхүүжилт авахаар өрсөлдөгч бизнесүүдээс эхлэн сонголт хийх боломжийг хөрөнгө оруулагчид олгох эрх.
56. “Портфель” компани (Portfolio company)- Венч капиталын компаний хөрөнгө оруулсан компаниудын нэг. Венч капиталын компани нь гол төлөв олон тооны бизнес/компаниудад хөрөнгө оруулдаг бөгөөд тэдгээрийг нийтэд нь ”багц” буюу “портфель”-ийн компаниуд гэж нэрлэдэг.
57. Өмчийн санхүүжилт (Equity Financing): Компаний өмчийн зарим хэсгийг хөрөнгө оруулагчид зарах замаар санхүүжилт татах хэлбэр.Үүний үр дүнд хөрөнгө оруулагч компаний нэг эзэмшигч, хувь нийлүүлэгч болдог.
58. Гүүр-зээл (Bridge loan)- Үндсэн хөрөнгө оруулалт орж ирэх хооронд түр зуур, богино хугацаатайгаар олгох/авах зээл.
59. Мухардал (Deadlock)- Нөөцийн хангамж, хөрөнгө оруулалт тодорхойгүй болон бусад шалтгааны улмаас үйл ажиллагаа зогсож, хүлээлтийн байдалд орох төлөв байдал.

60. Эргэлтийн цэг (Pivot)- Гарааны бизнес түргэн хугацаанд бизнесийн чиглэл, стратегиа өөрчлөх үйл явц.
61. Хүү болон татварын өмнөх орлого(Earning/revenue before interest and tax/ EBIT)- Хүү болон татвар төлөхийн өмнөх орлого бөгөөд компаний үйл ажиллагааны үр ашгийн үзүүлэлт болдог.
62. Сарын дундаж орлого(Average revenue for month)- Бизнесээс сард дундажаар олж буй орлого. Нийт орлогыг сарын тоонд хувааж тооцно.
63. Сарын дундаж ашиг(Average profit for month) – Сард дундажаар бизнесээс олж буй ашгийн хэмжээ бөгөөд нийт ашгийг сарын тоонд хувааж тооцдог.
64. Сарын дундаж эргэлт(Average monthly turnover) – Сард дундажаар хийгдсэн нийт төлбөр тооцоо, гүйлгээний дүн.
65. Өгөөжийн дотоод түвшин (Internal rate of return/ IRR) – Орлогын дотоод хувь бөгөөд мөнгөн урсгал(cash flow)-ын өгөөжийг харуулдаг.
66. Бүтээгдэхүүн гаргалт (Product launch)– Бүтээгдэхүүнийг албан ёсоор гаргаж эхлэх үйл явц.
67. Бүтээгдэхүүний анхдагч загвар(Prototype) – Бүтээгдэхүүнийг бодитоор анхлан бүтээсэн хувилбар бөгөөд шалгах, турших, улмаар сайжруулах зорилготой.
68. Бүтээгдэхүүний энгийн туршилтын хувилбар(Minimum Viable Product/MVP)- Бүтээгдэхүүний хамгийн энгийн загвар. Үйлдвэрлэл, зах зээлд турших зорилгоор, наад захын шаардлагад нийцүүлэн бүтээдэг. Үүнийг гаргаж турших нь гарааны бизнес эрхлэгчид олон тооны алдаанаас зайлсхийх, цаашид бүтээгдэхүүнээ амжилттай хөгжүүлэх боломж олгохын зэрэгцээ өөрийн төсөөлөл, таамаглалыг шалгах, потенциал хэрэглэгчиддээ бүтээгдэхүүнээ таниулах хялбар арга зам юм. “MVP” –ийн үндсэн шинжүүд:
 - Бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн худалдан авах, хэрэглэх сонирхлыг татахуйц үнэ цэнтэй байх;
 - Эхлэн худалдан авагчдад илүү ашигтай, ирээдүйд илүү ашиг тус өгнө гэдгийг харуулах;
 - Цаашид бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд хэрэг болохуйц хэрэглэгчдийн эргэх холбооны мэдээлэл цуглуулах;
69. Үйлчилгээний програм хангамж (Software as a Service /SaaS)- Програм хангамжийн бүтээгдэхүүн нь бусдын хэрэгцээг хангахад чиглэсэн үйлчилгээ болох хэлбэр.
70. Зах зээлд гарах стратеги (Go-to-market strategy)– Бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргах маркетинг, борлуулалтын стратеги.
71. Үнэ төлбөргүй ашиглах (Freemium) - “free” – «төлбөргүй», premium – «шагнал» гэсэн үгнээс гаралтай ба суурь бүтээгдэхүүн, үйлчилгээг үнэ төлбөргүй, бусад нэмэлт зүйлсийг төлбөртэй ашиглахыг санал болгодог бизнесийн загвар.
72. Хэмнэлт (Lean) –Ямарваа алдагдал, хохирлыг хамгийн бага түвшинд хүргэх эрмэлзлэл.
73. Ашиг ба алдагдал (Profits and losses/P&L) – Орлого болон зардлын ялгавраар тодорхойлогдох санхүүгийн төлөвлөлт ба тайлангийн үзүүлэлт.

74. Эргэлт (Turnaround)- Алдагдалтай байгаад ашиг олж эхлэх шилжилтийн үе.
75. Ратчет (Ratchet) – Компаний удирдлагад хувьцаа эзэмшүүлэх үйл ажиллагаа бөгөөд урьдчилан тохирцсоны үндсэн дээр хэрэгжүүлдэг.
76. Орлого хуваарилалт(Revenue sharing) – Олсон орлогыг бизнесийн түншүүдийн хооронд хуваарилах ажиллагаа.
77. Туршлагаа ярих (Storytelling) – Үгчилбэл түүх ярих гэсэн үг. Бодит үйл явдлыг ярих замаар мэдээлэл, санааг хүмүүст хүргэх арга хэлбэр.
78. Татлага (Traction) – Бүтээгдэхүүн/үйлчилгээ зах зээл дээр эрэлт хэрэгцээтэй байгааг нотлох хэрэглэгчдийн зүгээс ирүүлсэн эерэг санал, үнэлгээ.
79. Хожил (Upside) – Хувьцааны үнэлгээ өсч хүртэх ашгийн хэмжээ нэмэгдэх үйл явц.
80. Дуусаагүй үйлдвэрлэл, үйл ажиллагаа(Work in progress/ WIP) – Явагдаж байгаа үйл ажиллагаа, хэсэгчлэн биелэгдсэн гэрээ.
81. Аутсорсинг (Outsourcing) – Гадны эх үүсвэр, нөөц ашиглах, ажил үйлчилгээг өөр байгууллагаар гүйцэтгүүлэх ажиллагаа(ацаглах).
82. Үүрэг амлалт(Commitment) – Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд бэлэн байх, хэрэгжүүлэх.
83. “Мэнтор”(Mentor)- Туршлагатай зөвлөх, хувийн мэдлэг, дадлагадаа тулгуурлан гарааны бизнесийн төсөлд зөвлөгөө өгдөг, хөрөнгө оруулалт, түнш олоход тусалдаг хүмүүс бөгөөд материалаг болон мөнгөн туслалцаа, дэмжлэг үзүүлдэггүй, “халамжлан хүмүүжүүлэгч” хэлбэрээр ажилладаг.
84. Чиглүүлэгч(Facilitator)– Арга хэмжээг төлөвлөгөө, дэгийн дагуу зохион байгуулах ажлыг хариуцаж, оролцогчдыг чиглүүлэн хөтлөгч, идэвхжүүлэгч.
85. Мэргэжлийн зөвлөх(Consultant)- Тодорхой нарийн мэргэжлийн салбар, хүрээнд шинжээчийн мэдлэг, чадвартай мэргэжилтэн. Мэргэжлийн зөвлөхүүд техник, технологи, инженеринг, электроникс, физик, хими, менежмент, бизнес, санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүй, хүний нөөц, маркетинг, олон нийтийн харилцаа(PR), боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд г.м. чиглэлээр мэргэшсэн байдаг.
86. Зөвлөгч (Advisor/adviser)- Тодорхой асуудал, хүрээнд болон чиг үүрэг, салбар дундын шинжтэй олон талт мэдлэг, чадвартай хүн. Мэргэжлийн зөвлөхөөс ялгагдах гол шинж нь манлайлан дагуулах, идэвхжүүлэх, чиглүүлэх үүрэгтэй.
87. Бизнес дасгалжуулагч (Business Couch)- “Ажил хэргийн дасгалжуулагч”, гарааны бизнес болон ЖДҮ, бизнес эрхлэгчдэд заавар, чиглэл, зөвлөгөө өгөх замаар спортын дасгалжуулагч шиг бизнесийн “тоглолт”-ыг удирдан залагч.
88. Бизнесийг худалдах (Selling business)- Бизнес /компаний бүхий л хөрөнгө, үүргийг мөнгөөр солих процесс.
89. Бизнес/компанийг худалдан авах (Acquisition)- Бизнесийг худалдан авах, компаний хяналтын багцыг авч эзэмших ажиллагаа. Байгуулсан/хөрөнгө оруулсан компанийг худалдаж, бизнесээс гарах стратегийн түгээмэл хэлбэр.
90. Бизнесийн үнэлгээ (Valuation) – Гарааны компанийг үнэлэх, үнэ цэнийг

тодорхойлох үйл ажиллагаа бөгөөд санхүүжүүлэлт хийх болон бизнесийг худалдах/худалдах авах үед гол төлөв хийгддэг хөрөнгийн үнэлгээ.

91. Хөрөнгө оруулалтын дараах үнэлгээ (Post money)– Компаний авсан хөрөнгө оруулалтыг тусгасан үнэлгээ.
92. Хөрөнгө оруулалтын өмнөх үнэлгээ (Pre money)– Хөрөнгө оруулалт хийхээс өмнөх компаний үнэлгээ.
93. Ухаалаг хөрөнгө оруулалт (Smart money)- Чухам юунд, яагаад хөрөнгө оруулж байгаагаа урьдчилан сайтар судалж, мэдсэний ундсэн дээр санхүүжилт хийдэг гарааны бизнесийн хөрөнгө оруулалтын концепци.
94. Бенчмаркинг (Benchmarking)- Түвшин тогтоолт буюу тухайн бизнесийн байгууллага/компани өөрийн салбар болон зах зээлд эзлэх байр сууриа баттай тодорхойлж, хүрсэн түвшингээ тогтоон, тэргүүлэгчдийн ололт, туршлагаас суралцах үйл явц. Түүнчлэн өрсөлдөгчид болон зах зээлд тэргүүлэгчидтэй харьцуулахад тухайн бизнесийн өнөөгийн төлөв байдал, түвшин ямар байгааг хөрөнгө оруулагчдын зүгээс тогтооход бенчмаркингийг ашиглах явдал түгээмэл. Харьцуулалтын суурь түвшин(Benchmark) нь өрсөлдөгч компаний, эсвэл бизнес төслийн тооцооны үзүүлэлтүүд(ашиг, орлого, зах зээлд эзлэх хувь хэмжээ г.м.) байж болно.
95. Үйлдвэр, аж ахуйн газар (Enterprise)- Үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага/компани.
96. Захирлуудын зөвлөл (Board of directors)- Компаний хувь нийлүүлэгч-эздийн зүгээс томилсон нөлөө бүхий хүмүүсийн баг бөгөөд гол төлөв хөрөнгө оруулагчид, зөвлөхүүдээс бүрддэг.
97. Зөвлөх бизнес эрхлэгч (Entrepreneur in residence/EIR)- Венч хөрөнгө оруулалтын сан/компаний зүгээс өөрийнхөө хөрөнгө оруулсан старт-ап бизнес, кампаниудад зөвлөгөө, туслалцаа үзүүлэх үүрэгтэйгээр түр хугацаагаар хөлслөн ажиллуулж буй туршлагатай бизнес эрхлэгч – зөвлөгч.
98. Гарааны бизнесийн экосистем (Start-up ecosystem)- Гарааны бизнесийг үүсгэн, хөгжүүлэх таатай орчин бүрдүүлэх систем. Экосистемийг гарааны бизнесийн хөгжилд тодорхой үүрэг гүйцэтгэдэг янз бүрийн бүтэц, байгууллагууд бүрдүүлдэг.

Эдгээр нь:

- Дэмжигч байгууллагууд(Support organizations) - инкубатор(incubators), акселератор(accelerators), дундын ашиглалтын албан өрөө, талбай(co-working spaces) г.м.
- Сургалт, судалгааны байгууллагууд(Universities and Research organizations)- мэдлэг олгох, мэргэжилтэн бэлтгэх, хүний нөөцөөр хангах, шаардлагатай судалгаа явуулах, шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн бодит мэдээллээр хангах үүрэгтэй.
- Хөрөнгө санхүүгийн байгууллагууд(Funding organizations)- гарааны бизнест шаардлагатай хөрөнгө санхүүгийн эх үүсвэр болох, хөрөнгө оруулалт хийх, сан бүрдүүлэх үүрэгтэй.

- Үйлчилгээний байгууллагууд (Service provider organizations)- Бизнесийг эхлүүлэх, хөгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүй, санхүү, маркетингийн г.м. төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд .
 - Томоохон компани, корпорациуд (Large corporations)- Томоохон бизнесийн байгууллагууд гарааны бизнесийн бүтээгдэхүүн, үйлчилгээний гол худалдан авагч, хэрэглэгч болох, мөн хөрөнгө оруулалтын болон бусад дэмжлэг үзүүлэх боломжтой.
99. Гарааны бизнесийн экосистемийн түлхүүр орц (Key inputs of Start-up ecosystem)- Дараах 5 түлхүүр орцыг бий болгосноор тухайн улс оронд экосистем амжилттай бүрддэг болохыг 2014 онд АНУ-ын “Up Global” (TechStars) болон “Google for Entrepreneurs” байгууллагуудын хамтарсан судалгаагаар тогтоожээ.
- Орц-1. Ур чадвар (Skills)- Хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдлыг ханган, өөр өөр ур чадвар, мэдлэг, туршлага бүхий хүмүүсийг татан төвлөрүүлэх, хамтын ажиллагаа, харилцаа холбоо үүсгэх, хөгжүүлэх замаар урт хугацаанд хүмүүн капитал бий болгох.
 - Орц-2. Нягтрал (Density)- Олон төрлийн бизнесийн хабуудыг үүсгэх, бизнесийн зөвлөхүүдийн сүлжээг бий болгох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр уг салбарын талаарх ойлголт, мэдээллийг түгээх, эрдэмтэн судлаачдыг бизнес эрхлэгчидтэй холбох зэрэг нь экосистемийн нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг.
 - Орц-3. Соёл (Culture)- Гарааны бизнесийн өвөрмөц соёлыг бий болгох, бизнес эрхлэгчдийн ур чадвар, хамтын ажиллагааг хөгжүүлж, амжилттай энтрепренеруудын жишээг олон нийтэд түгээж, уналт ба алдаа нь уг бизнес эхэлж буй хүнд зайлшгүй тулгардаг зүйл гэдгийг ухамсарлуулан ойлгуулах, даван туулах арга зам байдгийн харуулах нь гарааны бизнес ирээдүйн амжилтанд хүрэх нэг гол нөхцөл болдог.
 - Орц-4. Капитал буюу Хөрөнгө (Capital)- Засгийн газрын зүгээс хөрөнгө оруулагчдыг уг салбарт татан оруулж, баялгаа шилжүүлэх, эдийн засгийг идэвхжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх дэд бүтцийг бий болгох, бодлого боловсруулагчдын өмнө старт-апуудыг хөрөнгөтэй холбох арга механизмийг илүү хялбар болгож өгөх шаардлага тавигдана.
 - Орц- 5. Хууль, эрх зүй (Law) - Хөрөнгө оруулалтыг татаж, өндөр эрсдэл бүхий тэй энэхүг салбарт капиталын нөөцийг нэмэгдүүлэхийн тулд нээлттэй татварын системийг бий болгох, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, тогтвортой байдлыг хангах шаардлагатай.
100. Инкубаци (Incubator)- “Бойжуулах, өсгөх”-гэсэн утга агуулгатай үг бөгөөд шинэ тутам бий болсон бизнес, старт-апуудад шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлж, халамжлан бойжуулах замаар, тэдгээрийн өсөлтийг хангаж, зах зээл дээр бие даан үйл ажиллагаа явуулах чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагаа. Уг үйл ажиллагаанд 3 үндсэн тал оролцдог. Эдгээр нь:
- “Бойжуулагч” буюу инкубатор
 - “Бойжигч” буюу шинээр бизнес эрхлэгч, старт-ап компани

- “Дэмжигчид”: хөрөнгө оруулагчид, банк санхүүгийн байгууллага, венч сангууд, зөвлөхүүд, төр, засгийн байгууллагууд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд

101. Инкубатор(Incubator)- Бизнесийг бойжуулах үйл ажиллагаа явуулах үндсэн чиг үүрэг бүхий зохион байгуулалтын бүтэц бөгөөд янз бүрийн төрөл, хэлбэртэй байдаг. Инкубаторууд гол төлөв бизнес, менежментийн зөвлөх болон мэдээлэл, санхүүгийн үйлчилгээ үзүүлж, байр талбай, тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй үнээр ашиглах боломж олгодог. Инкубаторт бойжих гэрээт хугацаа гол төлөв 2-3 жил байх ба үүний дараа бойжигчид инкубаторийг орхин гарч, бие даан ажиллаж эхэлдэг. Инкубаторууд старт-ап бизнес болон ЖДҮ-ийг хөгжүүлэх, инновацийн таатай орчин бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Зохион байгуулалтын хувьд бие даасан байгууллага хэлбэрээр, эсвэл аль нэг байгууллага, шинжлэх ухаан, технологийн паркийн бүрэлдэхүүний нэгж байдлаар үйл ажиллагаа явуулдаг.

102. Инкубаторын ангилал ба төрөл хэлбэрүүд(Classification and types of incubators)-

Үндсэн зорилгоор:

- Ашгийн инкубатор: Ашиг олох зорилгоор, компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулах ба бойжигчдын сонгон шалгаруулалтын нөхцөл, шаардлага өндөр, дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломж, чадвар сайтай байдаг.
- Ашгийн бус инкубатор: Гол төлөв төрийн болон төрийн бус байгууллага, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд үйл ажиллагаа явуулах ба сонгон шалгаруулалтын нөхцөл, шаардлага төдийлөн өндөр биш, үзүүлэх дэмжлэг, туслалцааны цар хүрээ бага, нөхцөл боломж харьцангуй доогуур байдаг.

Үйл ажиллагааны чиглэлээр:

- Бизнес инкубатор: Бизнесийн аливаа санааг бойжуулах, ЖДҮ, бизнесүүдийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.
- Технологийн инкубатор: Шинэ технологийг нэвтрүүлэх, нутагшуулах, хэрэглээний эргэлтэнд оруулах зорилготой. Бойжуулах гол зүйл нь шинэ технологи байдаг.
- Технологи, бизнесийн инкубатор: Сүүлийн жилүүдэд дээр 2 хэлбэрийг хамтад хөгжүүлэх инкубаторууд түгээмэл болж байна. Аливаа шинэ санаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, шинэ технологийг зах зээлд арилжаалах, бизнес болгон хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хэлбэр.

Түшиглэсэн байгууллагаар:

- Төрийн байгууллагын дэргэдэх инкубатор: Яамд, агентлагууд, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудыг түшиглүүлэн байгуулсан инкубаторууд бөгөөд ЖДҮ, бизнесийг хөгжүүлэх, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн

зорилготой ба энэ чиглэлд төр засгийн бодлогыг хэрэгжүүлэх нэгж болдог. Олон улсын туршлагаас үзэхэд энэ төрлийн инкубаторуудын үр өгөөж төдийлөн өндөр бус байдаг байна.

- Төрийн бус байгууллагын дэргэдэх инкубатор: Бизнес, аж үйлдвэрийн мэргэжлийн холбоод, эмэгтэйчүүдийн болон залуучуудын холбоо гэх мэт төрийн бус байгууллагууд дэргэдээ гишүүд дэмжигчиддээ үйлчлэх зорилгоор инкубатор байгуулж ажиллуулах туршлага дэлхий дахинд түгээмэл байна.
- Их сургууль, эрдэм шинжилгээ байгууллагын дэргэдэх инкубатор: Профессор багш нар, эрдэм шинжилгээний ажилтнуудын оюуны бүтээлийг зах зээлд арилжаалах, үйлдвэрлэл, практикт нэвтрүүлэх, бизнес болгон хөгжүүлэх, оюутнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, бизнес эрхлэх мэдлэг чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн зорилго бүхий нэгж бөгөөд технологи дамжуулах төв, инновацийн төв, бизнес инкубатор, технологийн инкубатор, технологи, бизнесийн инкубатор-лаборатори г.м. хэлбэрээр зохион байгуулж ажиллуулж байна.
- Шинжлэх ухаан, технологи, аж үйлдвэрийн паркийн инкубатор: Энэ хэлбэрийн инкубаторууд нь шинжлэх ухаан, аж үйлдвэрийн паркуудын бүрэлдэхүүний нэг чухал нэгж болдог бөгөөд гол төлөв бизнес инкубаторын төв байгуулан ажиллуулж байна.

103. Инкубацийн үе шатууд (Incubation stages)- Инкубацийн үйл ажиллагаа үндсэн үе шатууд:

- Бизнесийн төслийг зарлах, тэдгээрийг хүлээн авч, сонгон шалгаруулах,
- Бойжигчдыг элсүүлэх;
- Инкубацийн үйлчилгээ үзүүлэх, орлогын эх үүсвэр бүрдүүлэх;
- Бойжигч компаниудыг төгсгөж гаргах;
- Төгсөлтийн дараах хяналт, үйлчилгээ үзүүлэх

104. Инкубацийн үйлчилгээний үе шат(Incubation service stages)- Инкубацийн үйлчилгээний 3 үндсэн үе шат:

1. Инкубацийн өмнөх үйлчилгээ(Pre-incubation service): Инкубаторт бойжигчдын сонгох бэлтгэх хангах үйл ажиллагаа
2. Инкубацийн үйлчилгээ(Incubation service): Сонгон шалгаруулалтаар инкубаторт элссэн бойжигчдод чиглэсэн үндсэн үйлчилгээ
3. Инкубацийн дараах үйлчилгээ(Post-incubation service): Инкубаторт бойжиж, гарсан төгсөгч- компаниудад чиглэсэн үйл ажиллагаа

105. Бизнес-акселератор (Business acselerator) — Гарааны бизнес болон бизнес төслийг богино хугацаанд эрчимтэй хөгжүүлэх замаар бизнесийг дэмжих инкубацийн загвар бөгөөд сүүлийн жилүүдэд маш эрчимтэй хөгжиж байна.

106. Дундын ашиглалтын албан өрөө, талбай(Co-working spaces)- Өөрийн албан өрөө, байр байхгүй гарааны бизнес эрхлэгчдэд ажиллах нөхцөл бүрдүүлэх, хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх боломж олгох зорилгоор байгуулж, нийтэд нээлттэй үйлчилдэг бүтэц.

107. Гарааны бизнесийг эхлүүлэх, хөгжүүлэх, экосистем бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөрүүд(Activities and programs for Start-up business development and Ecosystem building)-

Бизнесийн ур чадвар бий болгох(Business Skills development) үйл ажиллагаа :

- “Загварчлах сэтгэлгээ”(Design Thinking)- Анх АНУ-ын Стэнфордын их сургуулиас боловсруулсан хувь хүн, ажилтны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, бүтээлч хандлагыг төлөвшүүлэх, илүү ашигтай, оновчтой шийдэл олох арга барил эзэмшүүлэхэд чиглэсэн богино хугацааны интерактив сургалтын тусгай хөтөлбөр. Сургалтыг тодорхой системчилсэн арга барилаар явуулах ба анх компьютерийн хулгана, iPhone зэрэг хувьсгалт шийдлүүдийг үүгээр гаргаж байжээ. Массачусетсийн технологийн их сургууль(MIT)-ийн “d. School”- иас мөн зохион байгуулдаг.
- Старт-ап 7 хоног(Start-up Weekend)- Бизнес санаа бодож, сэтгэж буй хүмүүсийг нэгтгэн, баг болгон ажилуулж, үр дүнгээр нь нэг долоо хоног буюу 54 цагийн дотор гарааны бизнес үүсгэх зорилготой арга хэмжээ. Анх 2008 оноос уг арга хэмжээг АНУ-д зохион байгуулж эхэлсэн байна.
- Хөрөнгө оруулагчийн Демо- өдөр(Investor Demo Day)- “Демо-дэй”, гарааны бизнес эрхлэгч өөрийн шинэ санаа, бүтээгдэхүүн, бизнес төслөө ирээдүйн хөрөнгөорлуулагчид, түншүүдэд танилцуулах үйл ажиллагаа. Сонгогдсон гарааны бизнес болон төслийн багууд олон улсад тогтсон дэгийн дагуу 3-5 минутын хугацаанд хөрөнгө оруулагч, зочид болон шүүгчдэд санаагаа танилцуулах ба бизнесийн тохиролцоо хийх боломж олгоно. Энэхүү арга хэмжээ нь гол төлөв гарааны бизнесийн эхлэлийн хөрөнгө (Seed Funding)-ийг босгох зорилготой байдаг.

Бизнесийн нягтрал бий болгох (Business Density/ hub development) үйл ажиллагаа:

- Гарааны бизнес, инновацийг хөгжүүлэх дэд бүтэц бүрдүүлэх замаар бизнес эрхлэгч, дэмжигч, зөвлөхүүдийг нэг газарт төвлөрүүлэхэд чиглэгддэг.

Гарааны бизнесийн соёл төлөвшүүлэх (Start-up business Culture) үйл ажиллагаа:

- Гарааны бизнесийн нэвтрүүлэг(Start-up Media broadcasting)- Олон нийтэд зориулан гарааны бизнесийн ололт амжилт, сургамжийн талаар ярилцлага, нэвтрүүлэг бэлтгэж, радио, ТВ болон нийгмийн сүлжээгээр дамжуулдаг. Энтрепренерүүдийн чөлөөт уулзалт (Drink Entrepreneurs)- 2013 оноос эхлэн зохион байгуулагдсан олон улсын арга хэмжээ. Дэлхийн 40 гаруй орон, ялангуяа өмнөд Азийн хотуудад түгээмэл болоод байгаа энэхүү томоохон брэнд үйл ажиллагааг албан ёсны эрхтэйгээр Улаанбаатар хотод зохион байгуулж эхэлсэн. Бизнесийн ертөнц дэх залууст танилын хүрээгээ тэлэх, бизнесийн хамтрагчаа олох, урам зоригоор өөрийгөө цэнэглэх боломж олгодог нэг оройны системтэй, чөлөөт хөтөлбөр.
- Старт-ап Грийнд(Start-up Grind)- Бизнес эрхлэлтийн туршлага судлах, мэдлэг

хуваалцах арга хэмжээ. Үндсэн 3 хэсгээс бүрддэг. Энтрепренерүүд нэг дор цуглан хамтдаа хооллож, бусадтай танилцах, салбартаа өндөр өсөлттэй бизнес эхлүүлж чадсан туршлагатай энтрепренерүүдийн яриаг тайзан дээрээс сонсож, ярилцах, төгсгөлд нь чөлөөт ярилцлага, асуулт, мөн харилцаа үүсгэх “нэтворкинг” явагддаг. Уг арга хэмжээг “Google for Entrepreneurs” сангаас дэмжин Америк, Хятад, Япон, Солонгос зэрэг 66 улсын 151 хотод сар бүр тогтмол зохион байгуулж байгаа ба энтрепренерүүдэд харилцан биенээсээ суралцаж, урам зоригоо сэргээх, харилцаа холбоогоо өргөтгөх боломж олгодог байна.

Гарааны бизнесийн санхүүжилт (Financing Start-up business):

- Шинээр бизнес эхлэгчдийн хувьд нэн тэргүүнд тулгамддаг, амин чухал зүйл бол санхүүжилт байдаг ба үүнийг 2 үндсэн эх үүсвэрээс авах боломж бий. Нэгд, Барьцаат хөрөнгө буюу банкны зээл, Хоёрт, хувь/хувьцаагаа барьцаалах буюу өмчийн хөрөнгө оруулалт. Шинэ технологи, инновацийн гарааны бизнесүүдийн хувьд гаргасан шинэ санаа, баг, бизнес эрхлэх чин эрмэлзэлээс өөр барьцаалах хөрөнгө байдаггүй тул банкууд тэр бүр зээл олгодоггүй. Иймд тэдгээр нь “Энжел” болон вэнч хөрөнгө оруулагчдад голчлон хандах хэрэгтэй болдог байна.

Гарааны бизнесийн хууль эрх зүйн орчин (Legal environment for Start-up business):

- Өндөр эрсдэлтэй гарааны бизнесийн салбарт хөрөнгө оруулалтыг татах, капитал нөөцийг нэмэгдүүлэх үүднээс хууль эрх зүйн таатай орчин бий болгох нь чухал. Ялангуяа оюуны өмчийн эрхийн баталгааг хангах, гарааны бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн механизм бүрдүүлэх шаардлагатай.
108. “Өрх тусгаарлах”(Spin-off/ Spin-out)- Тодорхой бизнес/компанийг хөгжүүлж, байгууллагаас тусгаарлан гаргаж, бие даалгах хэлбэр.
 109. “Шингэрэлт”(Dilution) — Үнэт цаасны зах зээлд хувьцаа нэмж гаргах, нэмэлт хөрөнгө оруулалт хийсний улмаас компанид эзэмших хувь багасах үйл явц.
 110. **Эзэмшил хувь**(Equity Stake) — Зөвлөгөө өгөх, удирдлага, санхүүжилтын үйл ажиллагаанд туслах зэрэг үйлчилгээ үзүүлсний нөхөн төлбөр болгож компаний хувьцаанаас хөрөнгө оруулагчид эзэмшүүлэх хувь.
 111. Компани татан буутгах (Liquidation)- Компаний бүх хөрөнгийг зарах замаар аж ахуйн нэгжийг татан буулгах үйл ажиллагаа.
 112. Нууцлалын гэрээ (NDA-Non-disclosure agreement)- Түншлэгч талууд бизнес, худалдааны үйл ажиллагааны нууцлалыг гуравдагч этгээдэд үл задруулах үүрэг хүлээж байгуулсан гэрээ.
 113. Гаралт(Exit)- Компаний хувь нийлүүлэгч өөрийн хувийг зарж, тухайн бизнесээс гарах үйл явц бөгөөд хөрөнгө оруулагчидтай голчлон холбоотой хэрэглэгддэг ойлголт.
 114. Нээлттэй хувьцаа гаргалт(IPO-Initial Public Offering)- Бизнесийн байгууллага нь

анх удаа хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргах үйл ажиллагаа. Ингэснээр уг аж ахуйн нэгж нь хувийн биш нийтийн эзэмшлийн хувьцаат компани болдог.

II хэсэг. ЭНТРЕПРЕНЕРШИП(ENTREPRENEURSHIP)-БИЗНЕС ЭРХЛЭЛТ

115. Энтрепренершип (Entrepreneurship)- Бүтээлчээр сэтгэж, шинэ зүйл санаачлан, ашиг олох зорилгоор бизнес эрхлэх үйл ажиллагаа. Энэхүү ойлголтыг “entrepreneur” гэсэн франц үгнээс гаралтай гэж үздэг. Анх 1723 онд Францид хэвлэгдсэн толь бичигт уг нэр томъёо тусгагджээ. 1920-иод онд Австрийн эдийн засагч Й. Шумпетер энтрепренершипыг чиглэлээр судалгаа хийж, нийгэм-эдийн засгийн хөгжилд түүний гүйцэтгэх үүрэг чухал гэдгийг тогтоосон байна. Тэрээр бие даан хувийн бизнес эрхлэгчид буюу “энтрепренерүүд” нь шинэчлэгч- “инноватор”-ууд байдаг бөгөөд тэдгээр нь ашиг орлого олох, нэмэгдүүлэх үүднээс үйлдвэрлэлийн хүчин зүйлс (хөдөлмөр, капитал, газар)-ийг урьд өмнө байгаагүйгээр оновчтой хослуулдаг ба “creative destruction” буюу “бүтээлч -устгал”-ыг хэрэгжүүлдэг нь урт хугацаанд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтөнд ихээхэн ач тустай хэмээн үзжээ. Ингэж “бүтээлч –устгал” явагдсанаар хуучин, үр ашиггүй зүйлс үгүй болж, цоо шинэ, илүү өгөөжтэй зүйлс бий болсноор бизнесийн шинэ салбар, чиглэл үүсч хөгжих үндэс болдог байна. Энтрепренершип нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлыг бууруулах, бизнесийг хөгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах, амьжиргааны түвшинг дээшлүүлэх чухал эх сурвалж болдог.
116. Энтрепренершипын төрөл (Types of Entrepreneurship)- Уг ойлголт ашиг олох зорилготой бизнесийн үйл ажиллагааг гол төлөв илэрхийлдэг байсан бол сүүлийн жилүүдэд илүү өргөн хүрээг хамарсан шинжтэй болж байна.
117. Нийгмийн энтрепренершип (Social entrepreneurship)- Ашиг олох зорилгоор бус, харин нийгмийн сайн сайхны төлөө явуулж буй нийгэм, хүмүүнлэг болон экологийн чиглэлийн бизнесийн үйл ажиллагаа. 2000-аад оноос бий болсон ойлголт.
118. Улс төрийн энтрепренершип (Political entrepreneurship)- Ашгийн төлөө бус, улс төрийн зорилгоор явуулдаг бизнесийн үйл ажиллагаа, нийгмийн энтрепренершипын нэг хэлбэр.
119. Мэдлэгийн энтрепренершип (Knowledge entrepreneurship)- Мэдлэгийн ашиглалтыг нэмэгдүүлэх, хэрэглээ болгон үйлдвэрлэл, практикт нэвтрүүлэх, үүнд чиглэсэн чадвар, боломж бүрдүүлэх үйл ажиллагаа. Уламжлалт энтрепренершип нь ашиг орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгддэг бол мэдлэгийн энтрепренершип нь ашгийн бус зорилготой судалгаа, боловсролын байгууллагуудад илүү тохиромжтой.
120. Угсаатны энтрепренершип (Ethnic entrepreneurship)- АНУ болон Европын үндэсний цөөнхийн төлөөллийн эрхэлж буй бизнес. Түүхээс үзэхэд IX-X зууны үед АНУ-д еврей худалдаачид, нийтийн хоол, зоогийн газар, фирмын аж ахуй эрхлэгч хятад, япон энтрепренерүүд цөөнгүй байв. Сүүлийн жилүүдэд Кубын бизнес эрхлэгчид Маямы мужид суурьшин үйл ажиллагаа явуулах болжээ.

121. Институцийн энтрепренершип(Institutional entrepreneurship)- Байгууллагын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн, үр өгөөжийг дээшлүүлэх, шинээр бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа. Байгууллагын үр дүн, үр өгөөжийг дээшлүүлэх, үнэ цэнийг нэмэгдүүлэх боломж олгох тийм зохион байгуулалтын бүтэц, институтыг бий болгоход уг үйл ажиллагаа чиглэгддэг ба сүүлийн жилүүдэд зохион байгуулалтын онолын судалгааны нэг шинэ чиглэл болон хөгжиж, судлаачдын анхаарлын татах болжээ.
122. Төслийн энтрепренершип (Project entrepreneurship)- Тодорхой төсөлд суурилсан бизнесийг хөгжүүлэхэд чиглэсэн, цаг үеийн шинжтэй байгууллага, зохион байгуулалтын бүтцийг бий болгож, удирдах үйл ажиллагаа. Өөрөөр хэлбэл, ямар нэг төслийг хэрэгжүүлэх, менежмент хийх чадвар бүхий багийг бүрдүүлж, энэ чиглэлээр мэргэшсэн хүмүүсийг “төслийн энтрепренер”-үүд гэж нэрлэдэг.
123. Технологийн энтрепренершип (Technology entrepreneurship)- Инноваци, шинэ технологийн бизнесийг дагнан эрхлэх үйл ажиллагаа.
124. Энтрепренершипийн үйл ажиллагаа (Entrepreneurial activity)- Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, шинэ зах зээлийг эзэмшихэд чиглэсэн үнэ цэн бүтээх эдийн засгийн үйл ажиллагаа.
125. Энтрепренер (Entrepreneur)- Өөрийн хүсэл эрмэлзлэлийн дагуу сайн дураар аз туршиж, бүтээлчээр сэтгэж, шинэ зүйл санаачлан, эрсдэл хүлээхэд бэлэн, бие даан хувийн бизнес эрхлэгч. “Энтрепренер” нь гол төлөв жижиг бизнесээр эхлэх боловч ердийн жижиг бизнес эрхлэгчээс ялгаатай гэж үздэг. Дийлэнх жижиг бизнес эрхлэгчид нь гол төлөв байгаа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг санал болгодог ба өсч хөгжих эрмэлзлэл, чадвар төдийлөн хангалтгүй байдаг бол энтрепренерүүд нь инновацийг нэвтрүүлэн, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, томоохон бизнес болгон хөгжүүлэх хүсэл эрмэлзлэлтэй байдаг.
126. Энтрепренерийн гол шинжүүд (Main characteristics of Entrepreneur)-
- Бүтээлч сэтгэлгээ, шинэ санаачилга (инноватор байх)
 - Манлайлал, удирдах ур чадвар
 - Баг бүрдүүлэх чадвар
127. Энтрепренерүүдийн ангилал (Types of Entrepreneurs)- Ангиллын хэд хэдэн шалгуураар авч үзэж байна.

1. Бизнесийн төрөл

- Бизнес эрхлэгч (Business entrepreneur)- Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны бизнес эрхлэгч
- Үйлдвэр эрхлэгч(Industrial entrepreneur)- Зөвхөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа дагнан эрхлэгч
- Үйлчилгээ эрхлэгч(Service entrepreneur)- Үйлчилгээний бизнес эрхлэгч
- Худалдааны бизнес эрхлэгч(Trading entrepreneur)- Гадаад, дотоодын зах зээл дээр худалдаа, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэгч
- Байгууллагын бизнес эрхлэгч(Corporate entrepreneur)- Байгууллагыг удирдах менежментийн үйл ажиллагааг бизнес болгон эрхлэгч

- ХАА-н бизнес эрхлэгч (Agricultural entrepreneur)- ХАА-н түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгч.

2. Технологи ашиглалт

- Технологийн бизнес эрхлэгч (Technological entrepreneur)- Үйлдвэрлэл, инженеринг, чанарын хяналт, хэмжилт, техникийн экспертизийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгч.
- Технологийн бус бизнес эрхлэгч (Non-technological entrepreneur)- Маркетинг, борлуулалт, түгээлт, стратегийн боловсруулалтын чиглэлээр ажилладаг бизнес эрхлэгч.
- Мэргэшсэн бизнес эрхлэгч (Professional entrepreneur)- Бизнес эрхлэх чиглэлээр туршлага хуримтлуулж, мэргэшсэн, ямар ч бизнесийг шинээр эхэлж, хөгжүүлэх чадвартай болсон байдаг.

3. Мотиваци

- “Цэвэр” энтрепренер (Pure entrepreneur)- Бизнес эрхлэх чин хүсэл сонирхолтой, эдийн засгийн өгөөж хүртэх эрмэлзлэлтэй.
- Боломж хүртэхийг эрмэлзэгч (Induced entrepreneur)- Бизнесийг дэмжих чиглэлээр төрөөс явуулж буй бодлого, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ зэрэг боломжууд бизнес эрхлэх гол мотив болдог.
- Төрөлхийн энтрепренер (Spontaneous entrepreneur)- Авхаалж самбаатай, аж ахуйч сэтгэлгээтэй бизнес эрхлэх төрөлхийн авъяастай хүмүүс.

4. Хөгжлийн үе шат

- Анхдагч үеийн бизнес эрхлэгч (First generation entrepreneur): Гэр бүлээсээ анхлан бизнес эрхэлж эхэлсэн аз туршигч, инноватор.
- Шинэ үеийн бизнес эрхлэгч (Modern entrepreneur): Зах зээлийн болон бусад өөрчлөлтөнд дасан зохицох чадвартай байдаг.
- Сонгодог бизнес эрхлэгч (Classical entrepreneur): Бизнесийн өсөлт, хөгжлөөс илүүтэй хэрэглэгчдээ анхаардаг, маркетингийн үйл ажиллагааг голчилдог.

Бусад

Байршилтаар:

- Хотын бизнес эрхлэгч
- Хөдөөгийн бизнес эрхлэгч

Хүйсээс:

- Эмэгтэй бизнес эрхлэгч
- Эрэгтэй бизнес эрхлэгч

Цар хүрээгээр:

- Бичил бизнес эрхлэгч
- Жижиг бизнес эрхлэгч
- Дунд зэргийн бизнес эрхлэгч
- Том хэмжээний бизнес эрхлэгч

Үйл ажиллагаа эрхлэлтийн шинж төлөв/давтамж:

- Ганцаарчилсан бизнес эрхлэгч (One-person enterprises/self-employed entrepreneur)
- Хагас цагийн бизнес эрхлэгч (Part-time entrepreneur)
- Зэрэгцээ бизнес эрхлэгч (Parallel entrepreneur)
- Цуврал бизнес эрхлэгч (Serial entrepreneurs)
- Бизнесийг дамжуулагч/хөгжүүлэгч (Business transfers and successions)

Бизнесийн хууль эрх зүйн хэлбэрүүд (Legal forms of Business):

1. Ганц хүний эзэмшил (Sole proprietorship)
 2. Нөхөрлөл (Partnership)
 3. Корпораци (Corporation)
 4. С- корпораци (S corporation)
 5. Хязгаарлагдмал хариуцлагатай компани (Limited liability company/LLC)
 6. Ашгийн бус байгууллага (Nonprofit organization)
128. Интрапренершип (Intrapreneurship)- Томоохон байгууллага, компаний дотоодод бизнес эрхлэх үйл ажиллагаа. Аж ахуйн тооцоотой нэгж, хөрөнгө оруулж “өрх тусгаарласан” (spin-off) байгууллагын хэлбэртэй байж болно.
129. Энтрепренершипийн боловсрол (Entrepreneurship education)- Суралцагчдад бизнес эрхлэлтийн талаар мэдлэг, чадвар олгох сургалт, бага сургуулиас эхэлж, шат шатны сургуулиудад заагдан, улмаар насан туршдаа хамрагдаж болох агуулга, арга хэлбэрүүдээр дэлхий дахинд явагдаж байна.
130. Энтрепренёр боловсролын нийтлэг зорилтууд (Main objectives of Entrepreneurship education):
131. Бизнес/ аж ахуй эрхлэхэд зайлшгүй шаардагдах мэдлэг олгох;
- Бизнесийн тодорхой нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, үйл ажиллагааг төлөвлөх аргуудыг эзэмшүүлэх;
 - Бизнесийн авъяас, ур чадварыг хөгжүүлэх, итгэл үнэмшил, урам зориг төрүүлэх;
 - Тулгарч болзошгүй эрсдэлийг олж харах, даван туулах арга техник эзэмшүүлэх;
 - Аз турших, өөрчлөлт, шинэчлэлтийн хандлагыг төлөвшүүлэх, инновацийг хөгжүүлэх чадвар олгох;
 - Шинэ бизнес эхлүүлэх, гарааны компани (Start-up) байгуулах мэдлэг чадвар олгох, дэмжлэг үзүүлэх;
132. Энтрепренёр боловсрол олгох сургалтын үндсэн хэлбэрүүд (Forms of Entrepreneurship education):
- **Академик боловсрол олгох сургалт** - Боловсролын зэрэг олгох болон мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр болон мэргэжлийн хичээлүүд энд хамрагдана. Жижиг бизнес, энтрепренершипийн чиглэлээр зэрэг(бакалавр, магистр, доктор) олгох болон мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрүүд түгээмэл байдаг. Түүнчлэн энэ талын хичээлүүдийг академик сургалтын

- бүхий л түвшинд заадаг уламжлал тогтжээ. Эдгээр нь “Entrepreneurship”, “Entrepreneurship management”, “Small business management”, “Entrepreneurship and Small business management” гэх зэргээр нэрлэгдэж байна.
- **Практик мэдлэг, чадвар олгох сургалт**- Олон улсын практикт хувийн жижиг аж ахуй, бизнес эрхлэгчдэд зориулсан олон тооны сургалтын хөтөлбөрүүд (Education and Training for Small Business Ownership) хэрэгжиж иржээ. Эдгээрийг 3 үндсэн төрөлд хувааж болно.
 - Шинэ бизнес, старт-ап компани байгуулах хүмүүст зориулсан Энтрепренёр боловсролын хөтөлбөрүүд (Entrepreneurial Education);
 - Насанд хүрэгчдэд зориулсан Жижиг бизнесийн сургалтын хөтөлбөрүүд (Continuing Small Business Education);
 - ЕБС-ийн сурагчдад зориулсан Жижиг бизнесийн мэдлэг олгох хөтөлбөрүүд (Small Business Awareness Education);
133. Бизнес төлөвлөгөө (Business plan)- Бизнес санааг хэрэгжүүлэх, оруулсан хөрөнгийг өсгөх, ирээдүйн үйл ажиллагааны дүр зургийг тусгасан баримт бичиг.
134. Бизнес төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд (Basic elements of a standard business plan)-
- Нүүр хуудас (Title Page)
 - Агуулга (Table of Contents)
 - Удиртгал (Executive Summary)
 - Компаний товч танилцуулга (Company Description)
 - Бүтээгдэхүүн/үйлчилгээний танилцуулга (Product/Service)
 - Зах зээл ба өрсөлдөөн (Market and Competition)
 - Маркетинг ба борлуулалтын стратеги (Marketing and Selling Strategy)
 - Үйл ажиллагааны төлөвлөгөө (Operating Plan)
 - Удирдлага/зохион байгуулалт (Management/Organization)
 - Санхүүжилт (Financing)
 - Нэмэлт мэдээллүүд (Supporting Document)

“ЗАЛУУЧУУДЫН ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР”-Т ХАМРАГДАЖ ЭХНИЙ БАЙРУУДАД ШАЛГАРСАН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Гарааны бизнесийг хөгжүүлэх, орон нутагт гарааны бизнесийн эко системийг бүрдүүлэх, залуучуудаар удирдуулсан гарааны бизнесийг бий болгох, дэмжих, орон нутгийн залуучуудыг сургаж, гарааны бизнес эрхлэх мэдлэг, чадвартай болгох зорилгоор гарааны бизнесийг дэмжих туршилтын хөтөлбөрийг ШХА-ийн Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлтэй хамтран 8 аймаг, дүүрэгт хэрэгжүүлээд байна.

Залуучуудын гарааны бизнесийг туршилтын төслийн талаар мэдээллүүдийг “Youth startup program” цахим хуудсанд байршуулан шинээр болох гарааны арга хэмжээний талаар зарлан мэдээлж байна.

№	Аймаг, дүүрэг	Огноо	Оролцогчид	Шалгарсан төсөл
1	Баянхонгор	2016.11.03- 2016.03.07	176 (79 эр, 97 эм)	<ol style="list-style-type: none"> 1. “Мазаалай” баг- “Өөрсдийн нөөцийг ашиглан хүүхдийн тараг үйлдвэрлэх” төсөл 2. “Энэр” баг- “Баянхонгор аймагт ноосон оймс үйлдвэрлэх” төсөл 3. “НүНомад” баг- “Орон нутгийн охидод зориулсан орчин үеийн дээл үйлдвэрлэх” төсөл
2	Хан-Уул	2016.11.09- 2016.11.11	88 (49 эр, 39 эм)	<ol style="list-style-type: none"> 1. “Ногоо өрөм” баг- “Мод тарих, ой болон уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хэрэглэх нүх өрөмдөх төхөөрөмж” төсөл 2. Шижир” баг- “Тойгны тосоор хийсэн ванны бөмбөлөг” төсөл 3. Ухаалаг гэрэл” баг- “Шинэлэг дизайн бүхий гэрэлтүүлгийн систем” төсөл
3	Баянгол дүүрэг	2017.02.02- 2017.02.05	89 (46 эр, 43 эм)	<ol style="list-style-type: none"> 1. “Livon” баг- “Мод болон ширээр тансаг зэрэглэлийн цүнх үйлдвэрлэх” төсөл 2. “ВИТГРАС” баг- “Витграс ургамлыг ашиглан дархлаа сайжруулах бэлдмэл үйлдвэрлэх” төсөл 3. “ВJB” баг- “Монгол хонины ноосоор эсгий хавтан хийх” төсөл

4	Дархан-Уул	2017.02.10- 2017.02.12	86 (50 эр, 36 эм)	<ol style="list-style-type: none"> 1. “Зөгийн бал” баг- “Нөөц бололцоогоо ашиглан органик зөгийн бал үйлдвэрлэх” төсөл 2. “Монгол медаль” баг- “Монгол өвөрмөц дизайнтай медаль үйлдвэрлэх” төсөл 3. “Хаан гагнуур” баг- “Зэвэрдэггүй материал ашиглан угаалгын өрөөний алчуур хатаагч үйлдвэрлэх” төсөл
5	Ховд	2017.03.17- 2017.03.19	81 (50 эр, 31 эм)	<ol style="list-style-type: none"> 1. “Гутал үйлдвэрлэл” баг- “Өвөрмөц загварын гутал үйлдвэрлэх” төсөл 2. “100 төгрөгийн хүч” баг- “Таван цул махаар өртөг багатай бууз, хуушуур хийх” төсөл 3. “B-grow” баг- “Ухаалаг хүлэмж үйлдвэрлэх” төсөл
6	Завхан	2017.04.17- 2017.04.19	89 (эр 42, эм 47)	<ol style="list-style-type: none"> 1. “Хот айл хязгааргүй хэрэглээ” баг- “Кинетик эрчим хүчээр ажилладаг цахилгаан үүсгүүр” төсөл 2. “Ногоон төгөл” баг- “Чацаргана, кальц агуулсан вакус” төсөл 3. “Эко хүнс” баг- “Хүлэмж ашиглан Завхан аймгийг нарийн ногоогоор хангах” төсөл
7	Говь-Алтай	2017.04.21- 2017.04.23	59 (эр 31, эм 28)	<ol style="list-style-type: none"> 1. “Алтай органик цай” баг- “Суль, сулхирын гурил орсон савласан сүүтэй цай” төсөл 2. “Нэгтгэл” баг- “Нүүрс ашиглан гаргасан шахмал эко түлш” төсөл 3. “Артишок” баг- “Артишок ургамлыг Говь-Алтай аймагт тарьж ургуулан зах зээлд савлан нийлүүлэх” төсөл
8	Өмнөговь	2017.05.19- 2017.05.21	59 (эр 34, эм 25)	<ol style="list-style-type: none"> 1. “Сүүн цацал” баг- “Ингэний сүүн чихэр болон сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх” төсөл 2. “Эгозавр” баг- “Хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх тоглоом” төсөл 3. “Гайхамшигт сонголт” баг- “Үнэт чулууг экспортод эцсийн бүтээгдэхүүн болгон гаргах” төсөл

9	<p>Өмнөговь аймгийн Ханбогд сум</p> <p>Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр ЗХЭД төслийн гарааны бизнесийг дэмжих загвараар зохион байгуулагдсан.</p>	2017.07.21-2017.07.23	74 (эр 24, 50 эм)	<ol style="list-style-type: none"> 1."Хүүхэд хөгжил" баг- "Хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх" төсөл 2."Органик гоо сайхан" баг- "Тэмээний чөмөг, бөх болон ингэний сүү ашиглан үйлдвэрлэсэн органик саван" төсөл 3."Товийн шийдэл" баг- "Хуванцар сав дахин боловсруулан явган хүний замын хавтан үйлдвэрлэх" төсөл 4."Ханбогдын баялаг"баг- "Том машины дугуйг дахин боловсруулан резинэн үүрмэг болгох" төсөл 5."Цогц шийдэл" баг- "Тавилга үйлдвэрлэх" төсөл 6."Товийн уран" баг- "Оюу толгой үйлдвэрийн ажиллчдад зориулсан цүнх үйлдвэрлэх" төсөл 7."Арьсан гутал урлал" баг- "Арьсаар гутал үйлдвэрлэх" төсөл 8."Түрээсийн машин" баг- "Дуудлагаар үйлчлэх түрээсийн машин ажиллуулах" төсөл
10	Ховд аймгийн Үенч сум	2017.09.13-2017.09.15	41 (эр 23, эм 18)	<ol style="list-style-type: none"> 1."Үенч Жаргалан буйдан" баг- "Ховд аймгийн Үенч суманд тавилга үйлдвэрлэх" төсөл 2."Чацаргана" баг- "Чацаргана тариалах, хураах, хөдгөлөх цогц үйлчилгээ үзүүлэх" төсөл 3."Өндөглөсөн тахиа" баг- "Тахианы аж ахуй эрхлэх" төсөл
11	Увс аймар	2017.10.02-2017.10.04	57 (эр 34, эм 23)	<ol style="list-style-type: none"> 1."Мод леги" баг- "Хүүхдийн модон тоглоом үйлдвэрлэх" 2."Ясны тостой эдийн саван" баг- "Ясны тостой чацарганатай эдийн саван үйлдвэрлэх" 3."Төгс шийдэл" баг- "Өрхийн хэрэгцээнд ашиглах жижиг машин үйлдвэрлэх"
12	Баян-Өлгий аймаг	2017.10.06-2017.10.08	65 (эр 39, эм 26)	<ol style="list-style-type: none"> 1."SAKHAR" баг- "Эмийн ургамалтай казак үндэсний саван үйлдвэрлэх" 2."Эко зуух" баг- "3 өдөрт 1 галладаг зуух үйлдвэрлэх" 3."Sara" баг- "Казак үндэсний цагаан идээ үйлдвэрлэх"

START UP-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГААС

1. “Start Up Mongolia” Төрийн бус байгууллага

Website: startupmongolia.com Facebook: [startupmongoliacom](https://www.facebook.com/startupmongoliacom) Tel: +967-8000 2863

**ЭНТРЕПЕНЕР
ЭКОСИСТЭМ
ХӨГЖҮҮЛЭГЧ**



“СТАРТАП МОНГОЛ” ТББ нь

дэлхий даяар сүлжээтэй, өндөр хэмжээнд төлөвшсөн бизнес хурдасгуур хөтөлбөрүүдээр дамжуулан Монгол улсын стартап экосистемийг хөгжүүлэх үндсэн зорилготой байгууллага юм. Энтрепренер хүсэл эрмэлзэлтэй хэнийг ч бид дэмжин ажиллаж, өндөр өсөлттэй бизнесийг бий болгоход нь бүх талаар дэмжин ажилладаг.



ХЙСЭН АЖИЛУУД /тоон хэлээр/

230

Үйл ажиллагаа зохион байгуулав

6

жил эрчимтэй үйл ажиллагаа

40'000

залуусыг биечлэн үйл ажиллагаанд хамруулав

8.7

Тэрбум төгрөгийг гишүүн стартапууд босгов

54

тв нэвтрүүлэг

400

стартап төслийг дэмжин ажиллав

Залуучуудын гарааны бизнес, бизнес инкубацийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын жагсаалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын www.hudulmur-halamj.gov.mn цахим хуудаснаас танилцана уу.

Website: startupmongolia.com Facebook: [startupmongoliacom](https://www.facebook.com/startupmongoliacom) Tel: +967-8000 2863

БИДНИЙ

АЛСЫН ХАРАА:

Монголд энтрепренер экосистем, хүрээллийг бий болгож дэлхийд өрсөлдөх Монгол компанийг дэмжих, бойжуулахад бидний алсын хараа оршино.

ГОЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Стартап компаниудыг нээж, хөгжүүлж, дэмжиж, хөгжлийг нь хурдасгаж, хөрөнгө оруулах нь бидний гол ажиллагаа юм.

ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ПРОГРАМУУД:

- Startup Weekend
- Pre-Accelerator
- Drink Entrepreneur
- Work Central
- Design Thinking
- Google Business Group
- Startup Grind
- Startup Train
- Innovator Education
- Гарааны бизнес
- Startup Base
- Startup Week

2.ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ


ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ

Хөгжлийн Шийдэл ТББ нь 2008 онд үүсэн байгуулагдсанаасаа хойш энтрепренёршиппийн боловсрол түгээх, өрхийн болон ЖДБизнесийг хөгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг шинэлэг, үр дүнтэй, шилдэг шийдлээр хэрэгжүүлсээр ирсэн, 2013 онд Лондон хотод төвтэй Youth Business International Олон улсын байгууллагын гишүүнээр элсн Залуусын Бизнесийг Дэмжих Санаачлага хөтөлбөрийг Монгол улсад хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь 18-35 насны залуусыг нийгмийн энтрепренёр болгон хөгжүүлж бизнес эхлэх болон эрхлэхэд дэмжин ажиллах зорилготой юм.



ХӨТӨЛБӨРИЙН УРИА

Залуусыг ажил хайгч бус ажил олгогч болгоход нь дэмжье!



ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНД

- Ажил хэрэгч нийгмийн энтрепренёр залуус
- Ментортой залуу бизнес эрхлэгчид
- Мэдлэг, туршлага, инноваци, хамтын үнэ цэнэ



БИД ЗАЛУУСЫГ ХЭРХЭН ДЭМЖДЭГ ВЭ?

- 💡 Бизнес/энтрепренёршиппийн ур чадвар олгох сургалтууд
- 👤 Менторингийн харилцаа
- 🌐 Сургалтын дараах бизнес зөвлөгөө
- 📶 Мэдлэг, туршлага хуваалцах хамтын клуб



ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ

YOUTH BUSINESS MONGOLIA хөтөлбөр 2013 - 2016 онд **1000** залууст хүрч, **692** залуусыг бизнесийн мэдлэг, ур чадвар сургаж, **12** гарааны бизнест **72** сая төгрөгний хөрөнгө оруулалтыг гадаад зах зээлээс босгож **100** бизнес ментор бэлтгэж, энтрепренёршиппийн **50** удаагийн сургалтыг зохион байгуулж олон улсын **3** удаагийн бизнесийн сургагч багш, чиглүүлэгч бэлтгэх сургалтыг эх орондоо зохион байгуулаад байна. Бидний үйл ажиллагааны үр дүнд **99** шинээр бизнес бий болж **276** залуу бизнес өргөжин сайжирсан.

"Би инновацийг бүтээдэг, би эрсдэлд ухаалаг ханддаг, би хүсэл эрмэлзлээрээ амьдардаг."

Залуу энтрепренёр



Хаяг: Улаанбаатар хот БЗД, Энхтайвны өргөн чөлөө 3-р хороолол, 32-р байр 19 тоот
Утас: 7722-4006
info@ybmongolia.org
Сошиал хуудас
www.facebook.com/youthbusinessmongolia
www.ybmongolia.org



3. ТӨВ АЙМГИЙН START UP ТӨВ -“МАЙНДСЕТ” МСҮТ



Монгол, Сингапур, Хятад, Израйль улсын компаниуд хамтран Төв аймгийн Батсүмбэр суманд хэрэгжүүлж байгаа “Шинэ Батсүмбэр төсөл”-ийн дэргэд 2015 онд Майндсет МСҮТ байгуулагдсан. Түүнчлэн хөдөө аж ахуйн салбарын Залуучуудын гарааны бизнесийг дэмжих төвийг Төв аймгийн Зуун мод хотноо байгуулж сумдын гарааны бизнес аж ахуй эрхлэлтийг дэмжих ажлыг зохион байгуулж байна.



Зураг. Хичээлийн А байр.

Манай тэргүүлэх зорилт нь аймаг, сумдад хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний мэдлэг шингэсэн өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, ялангуяа судалгаа-хөгжил(R&D)-ийн бааз суурийг бий болгох, ажиллах хүчний сургалт (техникийн коллеж), гарааны бизнес, шинэ санааг дэмжих, старт-ап компаниудын өрсөлдөх чадварыг өндөрсгөн бэхжүүлэх, мөн орон нутгийн иргэдэд насан туршийн боловсролын үйлчилгээ үзүүлэх явдал юм.

Майндсет МСҮТ нь энэхүү зорилтдоо хүрэхийн тулд Төв аймгийн Батсүмбэр сумд хүнс, хөдөө аж ахуй, бүтээлч үйлдвэрлэл, барилга, үйлчилгээний салбарын мэргэжил эзэмшүүлэх сургалтын орчинг бий болгосон бөгөөд энтрепренёрууд, гарааны бизнесийг нь хөгжүүлэх зорилгоор Зуунмод хотод гарааны бизнесийн хөгжлийн төв (StartUp hub)-ийг мөн байгуулсан. Суралцагчдын онолын мэдлэг, энтрепренёр ур чадварыг хөгжүүлэхээс гадна дотоод, гадаадын хөрөнгө оруулагч нартай холбоо тогтоох гүүр нь болж, гадаад зах зээлд гарахад нь туслахын төлөө ажиллаж байна.

Сургалтын хөтөлбөр: Майндсет МСҮТ-д 2 жил суралцана. Сургалтад насанд хүрсэн иргэдийг боловсролын түвшин харгалзалгүй элсүүлэн сургадаг. Сургалт “хосмог” сургалтын хэлбэрээр зохион байгуулагдана. Суралцагч эхний жилдээ гарааны бизнесээ эхлүүлэх мэдлэг, чадвар эзэмшинэ. 2 дахь жилдээ бизнесээ

амжилттай эрхлэхэд шаардлагатай ур чадвар эзэмших мэргэжлийн боловсролын хөтөлбөрт өөрийн сонгосон хөтөлбөрийн дагуу хамрагдана. Тухайлбал:

- Хүнс, Хөдөө аж ахуй (үхрийн аж ахуй, зөгийн аж ахуй, хүлэмжийн аж ахуй)
- Бүтээлч үйлдвэрлэл (marketing, branding, smart shopping, hand-made wool brands, souvenirs, tourist attractions)
- Барилга (Модуль барилга, гэр хорооллын эко шийдэл, ландшафт)
- Аялал жуулчлал (зочид буудал, ресторан, аяллын багц үйлчилгээ, тээвэр, хөтөч, орчуулагч)

Сургалтын үе шат: Сургалт нь дараах 3 үе шатнаас бүрддэг. (2 жил)

1. Энтрепренёр модулийн сургалт – 1 жил
2. Мэргэжлийн боловсролын сургалт – 1 жил
3. Гарааны бизнесээ эхлүүлэх (Элсэн суралцсанаас эхлэх боломжтой)

Сургалтын орчин. Тус МСҮТ нь хичээлийн 6 байртай. 350 оюутны хүчин чадалтай.

- Хичээлийн А байр (Бүтээлч үйлдвэрлэл, Хүлэмжийн аж ахуй, Барилга)
- Хичээлийн Б байр (Мах, сүү боловсруулах, Агуулахын аж ахуй)
- Хичээлийн В байр (Үхрийн аж ахуй, Хүлэмжийн аж ахуй, Зөгийн аж ахуй)
- Хичээлийн Г байр (Зочид буудал, Аялал жуулчлал)
- Хичээлийн Д байр (Барилгын дизайн, сургалт, үйлдвэрлэл, ландшафт)
- Зуунмод хот дахь СтартАп Хаб төв (сургалт, зөвөлгөө, хөрөнгө оруулалт)

СтартАп Хаб төвөөс нь дараах үйлчилгээнүүдийг авах боломжтой.

Үүнд: Энтрепренёр хөтөлбөрт суралцах, оффис түрээслэх, багаар ажиллах, бизнесийн уулзалт хийх, бизнес, санхүү-аудитын зөвлөх үйлчилгээ авах, дизайн студи ашиглах, хэвлэлийн олон нэр төрлийн үйлчилгээнүүд авах



Багшлах боловсон хүчин.

Үндсэн багш 7, зочин багш 8 ажиллаж байна. Гадаад 2 багштай.

MINDSET – a simple idea that makes all the difference...

(Хэн нэгнээс илүү байхдаа бус өөр байх чадвар нь “сэтгэлгээ” юм...)

www.mindset.mn

Утас: 99058594